



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 1/15

Зуунмод сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага” өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 7.2, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийсэн “Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн”, “Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг баталгаажуулсугай.

2. “Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн” гүйцэтгэлийн аудитаар бичигдсэн 16,661.8 сая төгрөгийн албан шаардлагыг хавсралт 1-р, “Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн” гүйцэтгэлийн аудитаар бичигдсэн 4,338.1 сая төгрөгийн албан шаардлага, 12.6 сая төгрөгийн төлбөрийн актыг хавсралт 2-р баталсугай.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Ч.Загдсүрэн нарт үүрэг болгосугай.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан 30 хоногийн дотор, илэрсэн алдаа зөрчлийг арилган, хэрэгжилтийг 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарт зөвлөсүгэй.

5. Аудитын тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Ч.Загдсүрэн нарт үүрэг болгосугай.


ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

019010071

G/Arkhib/Alban bichig 2024/ tushaal



Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/15 дугаар тушаалын хавсралт

№	Алдаа, зөрчлийн товч утга	Хариуцах байгууллага	Зөрчил төлбөрийн дүн /мян.төг/		Акт, албан шаардлага бичсэн аудитор
			Акт	Албан шаардлага	
1	Борнуур сумын соёл, спортын төвийн барилга 2020 оноос хэрэгжиж Жонт ХХК гүйцэтгэгчээр шалгарч, 2023 онд ашиглалтад орсон. Тус барилга нь 2023 оны 12 сард хүлээлгэн өгсөн, Соёлын төв 2024 оны 1 дүгээр сард орсон байна. Газар дээр нь ажиллахад зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн хэдий ч дотор заалны акустик хавтан хийгдээгүй, гадна тохижилтын ажлаас өвлийн улиралд хийх боломжгүй зогсоолын талбайн цутгалтын ажил хийгдээгүй байна.	БЗОСК ОНӨААТҮГ		30,500.0	Ахлах аудитор Л.Жаргалсайхан
2	Сэргэлэн сумын соёл, спортын төвийн барилга 2020 оноос хэрэгжиж Өгөөмөр Уул ХХК гүйцэтгэгчээр шалгарч, 2023 онд ашиглалтад орсон. Барилгын 60.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дотор халаалтын ажлын зургийг зохиогчтой зөвшилцөн захиалагчийн зөвшөөрлийг аваагүй өөрчилсөн, зургийн дагуу төсөв хийж хянуулаагүй, 10.9 сая төгрөгийн заалны урлагийн тайзны зургийг ашиглагчийн саналаар өөрчилсөн боловч захиалагчийн зөвшөөрлийг аваагүй.	БЗОСК ОНӨААТҮГ		71,600.00	Ахлах аудитор Л.Жаргалсайхан
3	Барилга, байгууламж ашиглалтад хүлээн авах комиссын актаар хүлээн авсан 14,518.2 сая төгрөгийн 4 барилга, байгууламжийг данс бүртгэлд тусгаагүйгээс 2,471.6 сая төгрөгийн Борнуур сумын соёлын төвийн барилгыг санхүүгийн тайлангийн аудитаар данс бүртгэлд тусгах албан шаардлага өгөгдсөн тул 12,046.6 сая төгрөгийн 3 барилга, байгууламжийг данс бүртгэлд тусгах	ОНӨГ		12,046,600.0	Ахлах аудитор Л.Жаргалсайхан Аудитор Ч.Загдсүрэн
4	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 24 барилга, байгууламжид олгосон материалын үнийн зөрүүг данс бүртгэлд тусгаагүй	ОНӨГ		4,513,127.1	Ахлах аудитор Л.Жаргалсайхан Аудитор Ч.Загдсүрэн
Нийт дүн			0.00	16,661,827.1	

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/15 дугаар тушаалын хавсралт

№	Алдаа, зөрчлийн товч утга	Хариуцах байгууллага	Зөрчил төлбөрийн дүн /мян.төг/		Акт, албан шаардлага бичсэн аудитор
			Акт	Албан шаардлага	
1	Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд 2022, 2023 онуудад тус бүр 800.0 сая төгрөг батлагдсан байхад Захиалагч БЗОСК ОНӨААТҮГ 2022 онд 40 айлын орон сууцны барилга болгон, төсөвт өртгийг 3,000.0 сая болгон өөрчилсөн нь холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн	БЗОСК ОНӨААТҮГ		3,000,000.0	Ахлах аудитор Л.Жаргалсайхан
2	Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх Төв цогт өлзийт ХХК-тай байгуулсан гэрээнд өөрчлөлт оруулахдаа тендерт санал болгосон 1 мкв нь 1.9 сая төгрөгийг материалын үнийн зөрүү гэж 2.0 сая төгрөг болгон өөрчилж, 80.0 сая төгрөгийн зөрүүг гүйцэтгэгчид олгосон байна	БЗОСК ОНӨААТҮГ		80,000.0	Ахлах аудитор Л.Жаргалсайхан
3	Орон нутгийн төсвөөс хэрэгжсэн барилга, байгууламж ашиглалтад хүлээн авах комиссын актаар хүлээн авсан 956.3 сая төгрөгийн авто зам, их засварыг данс бүртгэлд тусгаагүй байна.	Орон нутгийн өмчийн газар		956,300.9	Аудитор Ч.Загдсүрэн
4	Эрдэнэсант сумын соёлын төвийн их засварын ажилд 301.8 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт буюу нийт санхүүжилтийн 65 хувийг олгосон.	ХБТХОХэлтэс		301,788.4	Аудитор Ч.Загдсүрэн
5	Алтанбулаг сумын ЭМТ-ийн барилгын ажлын зохиогчийн хяналтад 2.7 сая төгрөгийг Досей ХХК-д илүү шилжүүлсэн байна.	ХБТХО-ын хэлтэс	2,680.1		Аудитор Ч.Загдсүрэн
6	Төв АЗЗА компанид Зуунмод сумын авто замын өвөл, зуны арчлалтын магадалшгүй ажлын зардал 2.8 сая төгрөгийг давхардуулж олгосон.	ХБТХО-ын хэлтэс	2,816.8		Аудитор Ч.Загдсүрэн
7	"Аймгийн төвийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажил"-ыг гүйцэтгэсэн Зуунмод цэцэрлэгжүүлэлт-ОНӨААТҮГ-т 1.3 сая төгрөгийн захиалагчийн зардлыг илүү олгосон.	Зуунмод сумын ЗДТГ	1,278.90		Аудитор Ч.Загдсүрэн
8	Зуунмод сумын дотор замын их засварын ажлын захиалагчийн зардал 2.9 сая төгрөгийг гүйцэтгэгч Төв АЗЗА ТӨХК-д илүү шилжүүлсэн байна.	Зуунмод сумын ЗДТГ	2,944.60		Аудитор Ч.Загдсүрэн
9	"Аймгийн төвийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажил"-ыг гүйцэтгэсэн Зуунмод цэцэрлэгжүүлэлт-ОНӨААТҮГ-ын 300.0 сая төгрөгийн гэрээт ажлын материалын үнэнд нийт 2.9 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон байна.	Зуунмод цэцэрлэгжүүлэлт-ОНӨААТҮГ	2,884.4		Аудитор Ч.Загдсүрэн
Нийт дүн			12,604.8	4,338,089.3	

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ,
ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ТӨАГ-2024/18-18-ШТА-ГА

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Ахлах аудитор Л.Жаргалсайхан
Утас: 70273465 Цахим хаяг: jargalsaikhanl@audit.gov.mn
Аудитор Ч.Загдсүрэн
Утас: 70272287 Цахим хаяг: zagdsurench@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Хүснэгтийн товъёг	1
Товчилсон үгийн тайлбар	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	3
А. Өмнөх жилүүдэд буюу 2022 оноос хэрэгжсэн, үнийн өсөлтийн зөрүү авсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн хувьд магадлалын дүгнэлтээр баталгаажаагүй төсөвт тусгагдсан байна.	5
А.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн ажлын даалгавар, техникийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрмийн дагуу боловсруулсан байна	5
А.2. 2022 оноос өмнө хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хувьд батлагдсан төсөвт өртөг, магадлалаар баталгаажсан төсөвт өртөгтэй харьцуулахад зөрүүтэй байна.	9
А.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг холбогдох журмын дагуу олгосон байна.	12
Б. Өмнөх жилүүдэд эрх шилжин хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүд цар тахлаас шалтгаалан гэрээний хугацаанд ашиглалтад ороогүй байна.	12
Б.1. Төсөл, арга хэмжээг холбогдох зураг төсөө, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлж ажилласан байна.	12
Б.2. Төсөл, арга хэмжээнд захиалагчийн, зохиогчийн болон зөвлөх үйлчилгээний хяналт хэрэгжсэн байна.	14
Б.3. Хэрэгжиж дууссан ашиглалтад хүлээлгэн өгсөн ажлын 63 хувийг данс бүртгэлд тусгасан байна.	14
В. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна	14
В.1. Хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлууд зориулалтын дагуу ашиглагдаж байна.	14
В.2. Хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээнүүд тэргүүлэх ач холбогдол бүхий төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.....	15
ДҮГНЭЛТ:	16
ЗӨВЛӨМЖ:	17

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1. Үнийн өсөлтийн зөрүү олгосон 24 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ	5
Хүснэгт 2. 2022 оноос эрх шилжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээ	7
Хүснэгт 3. Төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт өртөг, магадлалын дүгнэлтээр баталгаажсан төсөвт өртгийн харьцуулалт	9

Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
УИХ	Улсын Их Хурал
БЗОСК	Барилга захиалагч, орон сууцны корпораци
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗТХС	Зам тээвэр хөгжлийн сайд
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МЕД	Магдлалын ерөнхий дүгнэлт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭХС	Эрчим хүчний сайд

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дах зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол болон Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийлээ.
Аудитын зорилт	Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд: • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх, • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх, • Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх
Аудитын хамарсан хүрээ	Улсын төсвөөс эрх шилжин хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн, хяналт тавьж ажилласан аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ, ГХБХБГ, БЗОСК ОНӨААТҮГ, ОНӨГ, БШУГ зэрэг байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагаа, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамрууллаа.
Аудитын хязгаарлалт	Байхгүй.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. • МҮЕА-н баталсан Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөөнд тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд • Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Аймгийн таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 02 дугаар тогтоол • Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 01 дүгээр тогтоол • Аймгийн ИТХ-ын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн “Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” 01 дүгээр тогтоол • Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоол

- Аймгийн ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн "Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай" 02 дугаар тогтоол.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдаж, аудитын менежер О.Амаржаргал чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Ч.Загдсүрэн нар гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2024 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайлан, судалгааг 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр УАГ-т хүргүүллээ.


Хүндрэл бэрхшээл

А. Өмнөх жилүүдэд буюу 2022 оноос хэрэгжсэн, үнийн өсөлтийн зөрүү авсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн хувьд магадлалын дүгнэлтээр баталгаажуагүй төсөвт тусгагдсан байна.

А.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн ажлын даалгавар, техникийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрмийн дагуу боловсруулсан байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар улсын төсвөөс Төв аймагт 97,280.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31,970.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 32 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ эрх шилжин хэрэгжихээр батлагдсан. Үүнээс БСШУ-ны сайдын багцад батлагдсан ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаанд суурин болон зөөврийн компьютер худалдан авах 500.0 сая төгрөгийн ажил шинээр хэрэгжих бусад 31 нь он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээ байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт
/сайдын багцаар/



- БСШУСайд 17 ажил
- Соёлын сайд 4 ажил
- ЗГХЭГ 1 ажил
- Эрүүл мэндийн сайд 4 ажил
- Барилга, хот байгуулалтын сайд 1 ажил
- Эрчим хүчний сайд 1 ажил
- Зам тээврийн хөгжлийн сайд 4 ажил

Он дамжин хэрэгжсэн барилга байгууламж, зам, их засварын 31 ажлуудаас УИХ-ын 2021 оны 88, 2022 оны 72 дугаар тогтоолын дагуу үнийн өсөлт тооцсон 24 ажил, улсын төсвийн хөрөнгөөр 2022 оноос шилжин хэрэгжсэн 7 ажил байна.

Хүснэгт 1. Үнийн өсөлтийн зөрүү олгосон 24 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ

/сая төгрөг/

№	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ	Гүйцэтгэгч	Ашиглалтад хүлээн авсан огноо	Магадлалын дүгнэлтийн огноо дугар	2023 онд авсан үнийн өсөлтийн зөрүү
1	Сургуулийн барилга 920 суудал /Төв, Батсүмбэр сум/	Клаймакс ХХК	2022.12.30	ЕД88-0256/2022	946.2
2	Спортын төрөлжсөн сургуулийн барилга, 640 суудал /Төв, Зуунмод сум/	Эл Си Би ХХК		ЕД88-139/2022	311.5
3	Сургуулийн барилга, 160 суудал /Төв, Дэлгэрхаан сум/	Дөрвөн лхагва ХХК	2021.10.26	518/2022	227.2
4	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Төв, Заамар сум/	Сутай мандах ХХК	2023.12.18	88-0276/2022	462.7
5	Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар /Төв, Аргалант сум/	Тэнгэрийн долоон од ХХК	2022.08.22	88-223/20222	196.1

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

6	Хичээлийн А байрын барилгын их засвар /Төв, Зуунмод сум, Хүмүүн цогцолбор сургууль/	Голден прогресс ХХК	2022.11.25	88-493/2022	254.7
7	Сургуулийн дотуур байрын барилга, 40 ор /Төв, Архуст сум/	Хабул констракшн ХХК	2021.12.23	88-225/2022	102.2
8	Дотуур байрын барилга, 50 ор /Төв, Баянхангай сум/	Ар булаг ХХК	2021.10.04	88-158/2022	199.7
9	Сургуулийн дотуур байрын барилга, 75 ор /Төв, Мөнгөнморьт сум/	Хоргын чулуу ХХК	2022.12.15	88-381/2022	114.9
10	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Төв, Баянжаргалан сум/	Халзан хайрхан ХХК	2022.09.20	88-389/2022	85.4
11	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Төв, Эрдэнэсант сум/	Төв Цогт Өлзийт ХХК	2021.09.12	88-059/2022	112.7
12	Цэцэрлэгийн барилга /Төв, Угтаалцайдам сум/	Тэнгэрийн долоон од ХХК		88/145/2022	212.0
13	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Төв, Лүн сум/	Төв Цогт Өлзийт ХХК		88-074/2022	257.0
14	Соёлын төвийн барилга /Төв, Баянчандмань сум/	Мета менежмент ХХК	2022.09.27	88/145/2022	323.9
15	Соёл, спортын төвийн барилга /Төв, Борнуур сум/	Жоншт ХХК	2023.12.20	88-074/2022	477.1
16	Соёл, спортын төвийн барилга /Төв, Сэргэлэн сум/	Өгөөмөр Уул ХХК	2023.12.12	88-0351/2022	460.9
17	Соёл, спортын төвийн барилга /Төв, Баянжаргалан сум/	Их даян бүүвэй ХХК		88-432/2022	392.7
18	Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Төв, Архуст сум/	Виста групп ХХК	2021.12.17	88-0506/2022	45.5
19	Эмнэлгийн барилга, 15 ор /Төв, Баянцогт сум/	Арбулаг ХХК	2022.12.15	88-0534/2022	199.2
20	Эрүүл мэндийн төвийн барилга /Төв, Өндөрширээт сум/	Тэнгэрийн долоон од ХХК	2021.12.07	88-177/2022	259.9
21	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Төв, Эрдэнэсант сум/	Гранд авгуш ХХК		88-0287/2022	355.2
22	Зуунмод-Манзушир чиглэлийн хатуу хучилттай авто зам, 7км /Төв, Зуунмод сум/	Ялгуусан ХХК	2021.12.30		498.1
23	Сумын төвийн авто зам 3.2 км /Төв, Эрдэнэсант сум/	Ноблероуд ХХК	2021.03.20		55.7
24	Зуунмод сумын төвөөс Хөшгийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам /Төв, Зуунмод сум/	Анандын зам	2022.11.28		891.7
	НИЙТ				7442.2

Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль

Улсын төсвөөс 2023 онд 7,473.0 сая төгрөгийн үнийн өсөлтийн зөрүүг 2022 оноос өмнө хийгдсэн ажлууд дээр тооцож, магадлалын дүгнэлтийг үндэслэн олгосон байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд тусгагдан эрх шилжин хэрэгжиж буй дараах 7 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 2. 2022 оноос эрх шилжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээ

/сая төгрөг/

№	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ	хуулийн заалт	2023 оны төсвийн тухай хуулиар		
			эхлэх дуусах	төсөвт өртөг	санхүүжих дүн
1	Дотуур байрны барилга буулгаж, шинээр барих, 160 ор /Төв, Бүрэн сум, 1 дүгээр баг/	X.1.1.247	2022-2023	3,330.8	3,130.8
2	Дотуур байрны барилга, 160 ор /Төв, Зуунмод сум, 1 дүгээр баг/	X.1.1.318	2022-2023	2,095.6	1,675.6
3	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Төв, Жаргалант сум/	X.1.1.250	2022-2023	1,499.7	1,299.7
4	Нэгдсэн эмнэлгийн барилга, 50 ор /Төв, Зуунмод сум/	XV.1.76	2022-2023	5,475.7	3,902.8
5	Орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээ /Төв, Зуунмод сум/	IX.1.90	2022-2024	6,036.4	3,302.7
6	Дулааны станцын халаалтын 1, 2, 3, 4, 5, 6, 7 дугаар хэсгийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл /Төв, Зуунмод сум/	XIV.1.29	2022-2024	11,590.5	3,593.0
7	Баруун чиглэлд авто замаас Аргалант сумын төв хүртэлх авто зам, 7.1 км /Төв/	XII.1.1.64	2022-2023	8,424.1	7,124.1

Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд батлагдаж эрх шилжин хэрэгжсэн, үнийн өсөлт тооцсон болон он дамжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээнүүд нь өмнөх жилүүдийн аудитаар шалгагдсан архитектур төлөвлөлт, зургийн даалгаврын дагуу зураг төсөл хийгдэж, эрх бүхий холбогдох байгууллага албан тушаалтнаар баталгаажсан ажлууд байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй барилга байгууламжийн хувьд хуульд заасны дагуу техникийн нөхцөлийг холбогдох байгууллагуудаас авч шаардлагуудыг зураг төсөлд тусгасан. Олон жил үргэлжлэн хэрэгжиж буй зарим барилгын хувьд техникийн нөхцөлийн хугацаа дууссан, сунгалт хийгдэх шаардлагатай болсон байна. Тухайлбал:

- Зуунмод сумын спортын төрөлжсөн сургуулийн барилга /640 суудал/
- Угтаалцайдам сумын цэцэрлэгийн барилга /150 ор/
- Лүн сумын цэцэрлэгийн барилга /150 ор/
- Жаргалант сумын цэцэрлэгийн барилга /150 ор/
- Баянжаргалан сумын Соёл, спортын төвийн барилга
- Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл

Өмнөх жилүүдээс хэрэгжиж эхэлсэн зарим хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хувьд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөвт өртгийн дүнд багтаан барилга байгууламжийн ажлыг хэсэгчлэн, ажлын тоо хэмжээг хувааж тендер зарлан, гэрээ байгуулснаас шалтгаалж төсөвт өртөг нэмэгдсэн байна. Тухайлбал: Зуунмод сумын 640 хүүхдийн спортын төрөлжсөн сургуулийн барилга, Лүн, Угтаалцайдам, Жаргалант сумын цэцэрлэгийн барилга, Зуунмод сумын дотуур байрны барилга, Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн барилга.

- Угтаалцайдам сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга 1,300.0 сая төгрөгөөр 2021-2022 онд хэрэгжихээр батлагдсан. Тендерийг нэг маягийн зургаар хуулиар батлагдсан төсөвт өртөгт багтаан барилгын ажлын халаалт, салхивч, дулааны оролтын узель, дотор цэвэр бохир ус, дотор гадна цахилгаан, холбоо дохиолол, гадна дулаан, гадна ус, хангамж, гүний худаг, гадна тохижилт зэрэг ажлуудыг хасаж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Барилгын ажлын магадлалын дүгнэлт 2021 оны 9 дүгээр сарын 29-нд гарч, 2,178.2 сая төгрөг батлагдсан ба

Үндэсний аудитын газраас төсөвт өртгийг 842.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой гэж дүгнэсэн боловч 2023 онд нийт 912.8 сая төгрөгийн нэмэлт гэрээ хийснээс материалын үнийн зөрүү 212.0 сая төгрөг, зураг, төсөвт тусгагдсан дутуу ажилд 700.8 сая төгрөг байна.

- Лүн сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга 1,500.0 сая төгрөгөөр 2021-2022 онд хэрэгжихээр батлагдсан. Тендерийг нэг маягийн зургаар хуулиар батлагдсан төсөвт өртөгт багтаан барилгын ажлын халаалт, салхивч, дулааны оролтын узель, дотор цэвэр бохир ус, дотор гадна цахилгаан, холбоо дохиолол, гадна дулаан, ус, хангамж, гүний худаг, гадна тохижилт зэрэг хасаж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Барилгын ажлын магадлалын дүгнэлт 2021 оны 9 дүгээр сарын 29-нд гарч, 2,371.8 сая төгрөгийн төсөвт өртөг батлагдсан ба Үндэсний аудитын газраас төсөвт өртгийг 775.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой гэж дүгнэсэн боловч 2023 онд нийт 965.3 сая төгрөгийн нэмэлт гэрээ хийснээс материалын үнийн зөрүү 257.0 сая төгрөг, зураг, төсөвт 708.3 сая төгрөгийн ажил дутуу тооцогдсон байна.
- Зуунмод сумын 640 хүүхдийн сургуулийн барилга нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 3,978.4 сая төгрөгөөр 2019-2021 онд хэрэгжихээр батлагдсан. Барилгын ажлын төсөвт өртөг 5,002.6 сая төгрөгийг 2021 онд магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан байна. Тус барилга нь спортын төрөлжсөн сургууль бөгөөд бассейн, урлаг, спортын заалтай байхаар төлөвлөгдсөн хэдий ч зураг төсөвт тусгагдаагүй бассейн, урлаг, спортын заал, тамирчдын бэлтгэлийн өрөөнүүдийг стандартын дагуу болгох, тоног төхөөрөмжийг суурилуулах, гадна талбайд нэмэлт ажлуудыг хийхээр зураг төсөвт өөрчлөлт оруулан 2023 онд нийт 2,317.2 сая төгрөгийн нэмэлт ажлыг магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан байна.
- Зуунмод сумын 160 хүүхдийн дотуур байрны барилга 2,100.0 сая төгрөгөөр 2022-2023 онд хэрэгжихээр батлагдсан. Тендерийг нэг маягийн зургаар хуулиар батлагдсан төсөвт өртөгт багтаан барилгын ажлын гадна цахилгаан, холбоо дохиолол, дулаан, ус, хангамж, гадна тохижилт зэрэг ажлуудыг хасаж зарласан. Барилгын ажлын магадлалын дүгнэлт 2022 оны 8 дугаар сарын 03-нд гарч, 3,250.7 сая төгрөгийн төсөвт өртөг батлагдсан ба Үндэсний аудитын газраас төсөвт өртгийг 1,150.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой гэж дүгнэн 2023 онд 1,150.6 сая төгрөгийн нэмэлт гэрээ хийсэн байна.
- Жаргалант сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга 1,500.0 сая төгрөгөөр 2022-2023 онд хэрэгжихээр батлагдсан. Тендерийг нэг маягийн зургаар хуулиар батлагдсан төсөвт өртөгт багтаан барилгын ажлын халаалт, салхивч, дулааны оролтын узель, дотор цэвэр бохир ус, дотор гадна цахилгаан, холбоо дохиолол, гадна дулаан, ус, хангамж, гүний худаг, гадна тохижилт зэрэг ажлуудыг хасаж зарласан. Барилгын ажлын магадлалын дүгнэлт 2022 оны 12 дугаар сарын 12-нд гарч, 2,561.0 сая төгрөгийн төсөвт өртөг батлагдсан ба Үндэсний аудитын газраас төсөвт өртгийг 1,061.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой гэж дүгнэн 2023 онд 1,061.0 сая төгрөгийн нэмэлт гэрээ хийсэн байна.
- Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн барилга 2020 онд 744.6 сая төгрөгөөр төсөвт өртөгтэй батлагдсан, магадлалын дүгнэлтээр 1,281.8 сая төгрөг болсон. Нэг маягийн зургаар батлагдсан төсөвт өртөгт багтаан шал, дотор засал, гадна зам тайлбай, гадна цэвэр, бохир ус, гадна дулаан, цахилгаан, бохир, гадна холбоо дохиоллын ажлуудыг хасаж тендер зарлан гүйцэтгэгчийг шалгаруулсан. Гэрээний хугацааг 2023 оны 10 дугаар сарын 01 болгон сунгаж, үнийн өсөлтийн дүгнэлт гарсны дагуу 355.2 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Эдгээр асуудал нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх

¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.2.2.2² дахь заалттай нийцээгүй байна.

А.2. 2022 оноос өмнө хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хувьд батлагдсан төсөвт өртөг, магадлалаар баталгаажсан төсөвт өртөгтэй харьцуулахад зөрүүтэй байна.

Улсын төсвөөр хэрэгжүүлсэн 2022 оноос өмнө батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хувьд төсөвт өртөг, санхүүжих дүнг бодитой тооцож, төлөвлөөгүй байна.

Хүснэгт 3. Төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт өртөг, магадлалын дүгнэлтээр баталгаажсан төсөвт өртөгийн харьцуулалт

/сая төгрөг/

№	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ	Төсөвт өртөг		
		Тендер зарласан	Магадлалаар баталгаажсан	зөрүү
1	Сургуулийн барилга 920 суудал /Төв, Батсүмбэр сум/	4,907.8	8,875.0	3,967.2
2	Спортын төрөлжсөн сургуулийн барилга, 640 суудал /Төв, Зуунмод сум/	3,978.4	5,002.7	1,024.3
3	Сургуулийн барилга, 160 суудал /Төв, Дэлгэрхаан сум/	1,100.0	1,370.8	270.7
4	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Төв, Заамар сум/	1,500.0	1,736.0	236.5
5	Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар /Төв, Аргалант сум/	729.2	759.2	30.0
6	Хичээлийн А байрын барилгын их засвар /Төв, Зуунмод сум, Хүмүүн цогцолбор сургууль/	733.6	1,249.0	515.4
7	Сургуулийн дотуур байрын барилга, 40 ор /Төв, Архуст сум/	700.0	781.0	80.9
8	Дотуур байрын барилга, 50 ор /Төв, Баянхангай сум/	942.0	1,736.0	794.5
9	Сургуулийн дотуур байрын барилга, 75 ор /Төв, Мөнгөнморьт сум/	900.0	815.7	(84.3)
10	Дотуур байрны барилга буулгаж, шинээр барих, 160 ор /Төв, Бүрэн сум, 1 дүгээр баг/	3,351.0	3,330.8	(20.1)
11	Дотуур байрны барилга, 160 ор /Төв, Зуунмод сум, 1 дүгээр баг/	2,100.0	3,250.7	1,150.6
12	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Төв, Баянжаргалан сум/	800.0	780.2	(19.7)
13	Цэцэрлэгийн барилга /Төв, Угтаалцайдам сум/	1,300.0	2,178.2	878.1
14	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Төв, Лүн сум/	1,500.0	2,371.9	871.8
15	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Төв, Жаргалант сум/	1,500.0	2,560.9	1,060.9
16	Соёлын төвийн барилга /Төв, Баянчандмань сум/	1,500.0	1,538.1	38.1
17	Соёл, спортын төвийн барилга /Төв, Борнуур сум/	2,000.0	2,011.6	11.6
18	Соёл, спортын төвийн барилга /Төв, Сэргэлэн сум/	1,200.0	1,356.8	156.8
19	Соёл, спортын төвийн барилга /Төв, Баянжаргалан сум/	1,200.0	3,648.6	2,448.6
20	Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Төв, Архуст сум/	400.0	517.9	117.9
21	Эмнэлгийн барилга, 15 ор /Төв, Баянцогт сум/	1,700.0	1,376.8	(323.2)
22	Эрүүл мэндийн төвийн барилга /Төв, Өндөрширээт сум/	1,100.0	1,474.9	374.8
23	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Төв, Эрдэнэсант сум/	694.6	1,281.8	587.1

² Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

24	Нэгдсэн эмнэлгийн барилга, 50 ор /Төв, Зуунмод сум/	5,500.0	6,119.7	619.7
25	Зуунмод-Манзушир чиглэлийн хатуу хучилттай авто зам, 7км /Төв, Зуунмод сум/	6,576.9	7,753.5	1,176.6
26	Зуунмод сумын төвөөс Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам /Төв, Зуунмод сум/	8,161.7	8,056.8	(104.9)

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан төсвийн төлөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаж ажиллаагүй, иж бүрэн, магадлалаар баталгаажсан зургаар төсөв хийгдэж, түүнийг үндэслэн тухайн жилийн төсвийн хуульд тусгагдахгүй явж ирснээс батлагдсан төсөвт өртөг, магадлалаар баталгаажсан төсөвт өртгийн хооронд зөрүү гарч байна. Батлагдсан төсөвт өртгөөс магадлалаар батлагдсан төсөвт өртөг ихээхэн зөрүүтэй доорх барилгууд байна. Үүнд:

- Зуунмод сумын спортын төрөлжсөн сургуулийн барилга 1,024.2 сая төгрөг,
- Зуунмод сумын дотуур байрны барилга, 1,150.7 сая төгрөг,
- Батсүмбэр сумын сургуулийн барилга 3,967.2 сая төгрөг,
- Жаргалант сумын цэцэрлэгийн барилга 1,060.9 сая төгрөг,
- Баянжаргалан сумын соёлын төвийн 2,448.6 сая төгрөгөөр магадлалаар батлагдсан дүн, төсөвт өртгөөс их байна.

Мөн зарим төсөл арга хэмжээний батлагдсан төсөвт өртөг нь магадлалаар батлагдсан төсвөөс их байна. Жишээлбэл. Зуунмод сумын төвөөс Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам-104.9, Баянцогт сумын эмнэлгийн барилга-323.2, Мөнгөнморьт сумын дотуур байрын барилга-84.3 сая төгрөгөөр төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан дүн, магадлалаар батлагдсан дүнгээс их байна.

Ижил төрлийн барилгуудын хувьд батлагдсан төсөвт өртөг зөрүүтэй байх тохиолдол байна. Зуунмод, Бүрэн сумын дотуур байрны барилга аль аль нь 160 хүүхдийн багтаамжтай нэг хэвийн зурагтай, холболтын зургаар ялгаатай байх байтал 2022 оны төсөвт Зуунмод сумынх 2,100.0 сая төгрөг, Бүрэн сумынх 3,351.0 сая төгрөгөөр төсөвт өртөг нь батлагдсан байна.

Боловсролын сайдын багцад он дамжин хэрэгжсэн төсвийн тухай хуульд тусгагдсанаар 17,440.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 барилга байна. Үүнд 5 дах жилдээ буюу 2019 оноос хэрэгжсэн 1 барилга, 2020 оноос хэрэгжсэн 1, 2021 оноос хэрэгжсэн 2, 2022 оноос хэрэгжсэн 3 барилга байна.

- Зуунмод сумын 640 хүүхдийн спортын төрөлжсөн сургуулийн барилга нь 2019 оноос 5 дах жилдээ хэрэгжсэн байна. Тус барилгын МЭД нь 2019 оны 5 сард 5,002.7 сая төгрөгөөр баталгаажсан байна. Тус барилгын төсөвт өртөг 2019 оны төсвийн тухай хуульд 3,978.4 сая төгрөг, 2,000.0 сая төгрөгийн санхүүжилт, 2020 онд орхигдсон, 2021 онд 5,002.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 1,500.0 сая төгрөгийн санхүүжилт, 2022 онд санхүүжих дүн нь 622.6 сая төгрөгийн санхүүжилт, 2023 онд 5,284.1 сая төгрөгийн төсөвт өртөг, 311.4 сая төгрөгийн санхүүжилт буюу материалын үнийн өсөлт батлагдаж хэрэгжиж дууссан байна. Тус барилгын хувьд барилга хэрэгжиж эхлэхэд санхүүжилт нь төсөвт өртгийн 40 хувь, дараагийн жил 0 хувь, 3 дах жилд 30 хувь, 4 дэх жилд 12 хувь, 5 дах жилд материалын үнийн өсөлтөд санхүүжилт батлагдсан байна. Барилга баригдсан 5 жилийн хугацаанд нь нийт төсөвт өртгийн 72.0 хувьд санхүүжилт батлагджээ.
- Заамар сумын 320 хүүхдийн сургуулийн өргөтгөлийн барилга нь 2020 оноос хэрэгжиж, 2023 оны 12 сард буюу 4 дэх жилдээ ашиглалтад оржээ. Тус барилгын МЭД нь 2020 оны 9 сард 1,736.5 сая төгрөгөөр баталгаажсан байна. Тус барилгын төсөвт өртөг 2020 он, 2021 оны төсвийн тухай хуульд 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тусгагдаж, санхүүжих дүн нь 2020 онд 500.0 сая төгрөг, 2021 онд 1,000.0 төгрөгөөр, 2022 онд орхигдсон, 2023 онд 1,961.7 сая төгрөгийн

төсөвт өртөг, 462.7 сая төгрөгийн санхүүжилт буюу материалын үнийн өсөлт батлагдаж хэрэгжиж дууссан байна.

- Лүн сумын 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Угтаалцайдам сумын 1,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 150 хүүхдийн цэцэрлэг нь 2021 оноос 3 дах жилдээ хэрэгжсэн. Тус 2 барилгын 2021 оны 10 сард баталгаажсан МЕД-ээр Угтаалцайдам сум 2,178.2 сая төгрөг, Лүн сум 2,371.9 сая төгрөг байна. Барилгууд хэрэгжиж эхэлснээс хойш хугацаанд буюу 2022 он, 2023 онуудад хуулиар батлагдсан төсөвт өртөгт өөрчлөлт ороогүй, санхүүжилт нь эхний жилд 27-38 хувь батлагдаж, 2 дах жилд хуулиар батлагдсан төсөвт өртгийн үлдэгдлийг бүрэн санхүүжүүлсэн боловч батлагдсан төсөвт өртгийн 60 хувь байна. 2023 онд материалын үнийн зөрүүг өгсөн байна.
- Бүрэн, Зуунмод сумын 160 хүүхдийн дотуур байр, Жаргалант сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгууд 2022 оноос хэрэгжиж эхэлсэн. Бүрэн сумын дотуур байрны барилгын МЕД нь 2022 оны 6 сард 3,330.0 сая төгрөгөөр баталгаажж 2022 он, 2023 оны төсвийн тухай хуульд төсөвт өртөг нь бүрэн тусгагдсанаар эхний жил 200.0 сая төгрөг буюу 6 хувийн санхүүжилт батлагдсан боловч 2023 онд үлдэгдэл санхүүжилтийг баталснаар бүрэн хэрэгжих боломжтой болж, ашиглалтад ороход бэлэн болсон байна. Зуунмод сумын дотуур байрны барилгын МЕД нь 2022 оны 6 сард 3,250.7 сая төгрөгөөр баталгаажсан боловч 2022 он, 2023 оны төсвийн тухай хуульд төсөвт өртөг нь 2,100.0 сая төгрөгөөр батлагдаж, эхний жил 420.0 сая төгрөг буюу 20 хувийн санхүүжилт батлагдаж, 2023 онд хуулиар батлагдсан төсөвт өртгийн үлдэгдэл санхүүжилт батлагдсан нь МЕД-ээр баталгаажсан төсөвт өртгийн 65 хувь тул бүрэн хэрэгжих боломжгүй байна. Жаргалант сумын цэцэрлэгийн барилгын МЕД нь 2022 оны 12 сард 2,561.0 сая төгрөгөөр баталгаажсан боловч 2022 он, 2023 оны төсвийн тухай хуульд төсөвт өртөг нь 1,500.0 сая төгрөгөөр батлагдаж, эхний жил 200.0 сая төгрөг буюу 13 хувийн санхүүжилт батлагдаж, 2023 онд хуулиар батлагдсан төсөвт өртгийн үлдэгдэл санхүүжилт батлагдсан нь МЕД-ээр баталгаажсан төсөвт өртгийн 60 хувь тул бүрэн хэрэгжих боломжгүй байна.

Өмнөх жилүүдэд зураг, төсөвгүй ажлыг төсвийн тухай хуульд санхүүжилтийг дөнгөж ажил эхлүүлэхээр тусгаж ирснээс тухайн барилгын ажил хуулийн хугацаанд ашиглалтад орох боломжгүй, олон жил дамжин үргэлжлэх, хуулиар батлагдсан төсөвт өртөгт өөрчлөлт орж, гүйцэтгэгчтэй нэмэлт гэрээ байгуулах зэрэг асуудал гарсан байна.

Өмнөх онуудаас үргэлжлэн хэрэгжсэн доорх төсөл арга хэмжээг 2023 онд тусгахгүйгээр, санхүүжилт төлөвлөхгүйгээр орхигдуулсан байна.

- Заамар сумын Хайлааст багт хэрэгжиж буй 320 хүүхдийн суудалтай барилга нь 2021 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 3 дах жилдээ хэрэгжих байсан боловч 2023 онд санхүүжилт батлагдаагүйгээс барилгын ажил зогссон байна. Тус барилга нь 2021 он, 2022 онд төсвийн тухай хуулиар 2,865.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2021 онд 500.0 сая төгрөг, 2022 онд 300.4 сая төгрөгийн санхүүжилт, нийт 800.4 сая төгрөгийн санхүүжилт батлагджээ. Тус барилгын төсөвт өртгийг 2 удаа МЕД-ээр баталгаажуулсан байна. Эхний төсөв 2022 оны 1 сард 2,124.8 сая төгрөгөөр баталгаажсан нь төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт өртөгт багтаан баталгаажуулсан барилгын суурийн ажлын төсөв, тухайн оны 8 сард 4,085.1 сая төгрөгийн барилгын дээд хэсгийн ажил батлагдаж, нийт 6,209.9 сая төгрөгийн төсөвт өртөг МЕД-ээр баталгаажсан байна. Сургуулийн барилгын санхүүжилт нь хуулиар батлагдсан төсөвт өртгийн 28 хувь, МЕД-ээр баталгаажсан төсөвт өртгийн 13 хувь байна.
- Эрдэнэсант сумын эрүүл мэндийн төвийн барилга 2020 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2020 он, 2021 оны төсвийн хуулиар 744.6 сая төгрөгийн төсөвт өртөг, 2020 онд 50.0 сая төгрөг, 2021 онд 694.6 сая төгрөгийн санхүүжилт, 2022 онд орхигдсон байна. МЕД-ээр 2020 оны 10 сард 1,281.8 сая төгрөгийн төсөвт өртөг баталгаажсан байна. Гүйцэтгэгч Гранд аэгуш ХХК нь 2021 оны байдлаар төсвийн хуулиар батлагдсан санхүүжилтээс ажлын гүйцэтгэлээр 354.0 сая төгрөгөөр,

2023 онд үнийн өсөлтийн 355.2 сая төгрөгөөр санхүүжигдсэн байна. Эрүүл мэндийн төвийн барилгын санхүүжилт нь хуулиар батлагдсан төсөвт өртгийн 48 хувь, МЭД-ээр баталгаажсан төсөвт өртгийн 28 хувь байна. Тус барилгыг газар дээр очиж үзэхэд 2023 онд материалын үнийн өсөлтөд олгосон 355.2 сая төгрөгөөр барилгын ажлыг нэмж хийсэн байна.

А.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг холбогдох журмын дагуу олгосон байна.

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад багтлагдаж эрх шилжин хэрэгжсэн 31,970.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 32 ажлаас 500.0 сая төгрөг нь тоног төхөөрөмж худалдан авалт, үлдсэн 31,470.9 сая төгрөг нь 31 барилга байгууламж, их засвар, замын ажлын санхүүжилт байна. Үүний 7,442.2 сая төгрөг нь 24 барилгын ажлын гүйцэтгэгчид олгох материалын үнийн зөрүү, 24,028.7 сая төгрөг нь 7 барилга, байгууламжийн ажлын санхүүжилт байна. Урд оноос тайлант онд хэрэгжсэн 7 барилга, байгууламжийн ажлаас 8,424.1 сая төгрөгийн Аргалант сумын авто замын ажил бүрэн хэрэгжиж дууссан, 3 ажил 80-90 хувийн гүйцэтгэлтэй, 1 ажил 44.1 хувийн гүйцэтгэлтэй, инженерийн шугам сүлжээний 2 ажил 6-15 хувийн гүйцэтгэлтэй байна. Эдгээр ажилд 24,028.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоос, санхүүжилтийг ажлын бодит гүйцэтгэлд үндэслэн бүрэн олгожээ.

Б. Өмнөх жилүүдэд эрх шилжин хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүд цар тахлаас шалтгаалан гэрээний хугацаанд ашиглалтад ороогүй байна.

Б.1. Төсөл, арга хэмжээг холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлж ажилласан байна.

Тайлант жилд үнийн өсөлтийн зөрүү тооцож олгосон 24 төсөл арга хэмжээнээс 19 нь ашиглалтад хүлээлгэн өгсөн, 5 нь 2024 онд үргэлжлэн хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээнүүд байна. Эдгээр ажлыг ашиглалтад хүлээлгэж өгсөн оноор нь авч үзвэл:

- 2021 онд хүлээлгэн өгсөн ЕБС 1, дотуур байр 2, цэцэрлэг 1 их засварын ажил 1, ЭМТ-н барилга 1, замын ажил 2, нийт 8,
- 2022 хүлээлгэн өгсөн ЕБС 1, дотуур байр 1, цэцэрлэг 1, их засварын ажил 2, ЭМТ-н барилга 1, Соёлын төв 1, замын ажил 1, нийт 8,
- 2023 хүлээлгэн өгсөн ЕБС 1, Соёлын төв 2, нийт 3 төсөл арга хэмжээ байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдан 2022 оноос он дамжин хэрэгжиж буй 7 ажил 2023 онд хэрэгжсэн, үүнээс Аргалант сумын төв хүртэлх авто замын ажил 2023 онд бүрэн дуусаж хүлээлгэн өгсөн бол Зуунмод сумын орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажил хийгдээгүй санхүүжилт олгогдоогүй, бусад ажлууд 2024 онд үргэлжлэн хэрэгжиж байна.

Аудитын явцад эрх шилжсэн, үнийн өсөлтийн зөрүү авсан, он дамжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээнүүдээс Баянчандмань, Борнуур, Баянжаргалан, Сэргэлэн сумын соёлын төв, Заамар сумын ЕБС, Жаргалант, Угтаалцайдам, Лүн сумын цэцэрлэг, Эрдэнэсант сумын ЭМТ, Зуунмод сумын 640 хүүхдийн спортын төрөлжсөн сургууль, 50 ортой төрөх эмнэлэг, 160 хүүхдийн дотуур байр, дулааны станцын халаалтын 2 дугаар хэлхээний шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил зэрэг барилга байгууламжид захиалагч, гүйцэтгэгч байгууллагыг байлцуулан газар дээр очиж ажиллалаа.

ҮАГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу хаалга, цонхны хийц, материал, үнэ, шилний давхар, цонхны тавцан, шал, таазыг зураг, төсөвт тусгасны дагуу хийсэн эсэх, барилгын ажлын журнал буюу улаан журналаас бүх шатны хяналтаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн эсэхийг хянаж, карказан барилгын хувьд тулгуур баганын өргөн, бетоны маркыг шмидтийн алхаар хэмжсэн. Мөн дотор халаалтын шугамын диаметр, паар радиаторын үзүүлэлтийг зураг төсөвтэй тулган, гэрэлтүүлгийн тоо, розетканыг тоолж шалгалаа.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг газар дээр шалгаж ажиллахад доор асуудлууд илэрсэн. Үүнд:

- Борнуур сумын соёл, спортын төвийн барилга 2020 оноос хэрэгжиж Жонт ХХК гүйцэтгэгчээр шалгарч, 2023 онд ашиглалтад орсон. Тус барилга нь 2023 оны 12

сард хүлээлгэн өгсөн, Соёлын төв 2024 оны 1 дүгээр сард орсон байна. Газар дээр нь ажиллахад зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн хэдий ч дотор заалны акустик хавтан хийгдээгүй /30.5 сая төгрөг/, гадна тохижилтын ажлаас өвлийн улиралд хийх боломжгүй зогсоолын талбайн цутгалтын ажил хийгдээгүй байна. Гүйцэтгэгчид олгох санхүүжилтийг чанарын баталгааны 5 хувийг үлдээн олгосон тул дутуу ажлыг барьцаа мөнгөөр хийлгэн гүйцэтгэх боломжтой гэж үзсэн тул албан шаардлага өглөө.

- Сэргэлэн сумын соёл, спортын төвийн барилга 2020 оноос хэрэгжиж Өгөөмөр Уул ХХК гүйцэтгэгчээр шалгарч, 2023 онд ашиглалтад орсон. Тус барилгын дотор халаалтын /60.7 сая төгрөг/ зургийг зохиогчтой зөвшилцөн өөрчилсөн, заалны урлагийн тайзны /10.9 сая төгрөг/ зургийг ашиглагчийн саналаар өөрчилсөн боловч захиалагчийн зөвшөөрлийг аваагүй, өөрчилсөн зургийн дагуу төсөв хийж хянуулаагүй нь Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.17-д "барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн бол гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулах" гэснийг зөрчсөн тул албан шаардлага өглөө.



Борнуур сумын соёлын төв



Сэргэлэн сумын соёлын төв

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2022 оны жагсаалтад батлагдаж, гүйцэтгэгч нь шалгарч гэрээ байгуулсан хэдий ч ажил нь гүйцэт хийгдээгүй цаашид хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй дараах хоёр ажил байна.

Зуунмод сумын Орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажил 6,036.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2022 онд батлагдаж Мета менежмент ХХК гүйцэтгэгчээр шалгарч 6,036.4 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. 2022 оны төсөвт 900.0 сая төгрөг батлагдсан, 899.4 сая төгрөгийн ажил гүйцэтгэж гүйцэтгэлээр санхүүжилт авсан, 2023 онд 3,302.7 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан боловч ажил хийгдээгүй. Захиалагч байгууллагаас өгч буй тайлбараар 2019 оны зураг төсвөөр тендер зарлагдсан тул үнийн өсөлттэй холбоотойгоор батлагдсан төсөв, гэрээний дүнгээр гүйцэтгэх боломжгүй болсон байна.

Дулааны станцын халаалтын 1, 2, 3, 4, 5, 6, 7 дугаар хэсгийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл ажил 11,632.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2022 онд батлагдаж Эл Си Би ХХК гүйцэтгэгчээр шалгарч 11,590.5 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. 2022 оны төсөвт 420.0 сая төгрөг батлагдсан, 420.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэж гүйцэтгэлээр санхүүжилт авсан, 2023 онд 3,593.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан, 737.3 сая төгрөгийн ажил хийгдэж гүйцэтгэлээр санхүүжилт авсан. Мөн л үнийн өсөлттэй холбоотой гэрээний дагуу хэрэгжээгүй байна.

Дээрх ажлуудын зураг төсөв нь 2019 онд магадлалаар батлагдсан 2020 оноос цалингийн тарифт өөрчлөлт орсон, мөн цар тахлын улмаас бараа материалын үнэ нэмэгдсэн зэргээс шалтгаалан хэрэгжихэд хүндрэлтэй болсон байна. Зуунмод сумын цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой одоо баригдаж буй Дулааны станцын ажилтай нягт холбоотой, төсөл арга хэмжээ тул одоогийн дахин магадлал хийлгэж дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд гэрээг цуцлах, өөрчлөх зэргээр боломжтой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Б.2. Төсөл, арга хэмжээнд захиалагчийн, зохиогчийн болон зөвлөх үйлчилгээний хяналт хэрэгжсэн байна.

Захиалагч нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3-д заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна.

Захиалагчаар томилогдсон хяналтын инженерүүд нь үе шатны гүйцэтгэл бүрд хяналт хэрэгжүүлж, баталгаажуулсан байна. Мөн Дэд бүтцийн сайдын 2000 оны 09 дүгээр тушаалаар батлагдсан “Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл” буюу улаан дэвтэрт хяналтаар ажиллахад илэрсэн дутагдлыг арилгах талаар зөвлөмж бичиж байгаа боловч бүрэн гүйцэт биш, өгсөн зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж ажилласныг тэмдэглэхгүй байна.

Авто замын ажлуудад захиалагч зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна. Зөвлөх үйлчилгээ буюу хяналт хэрэгжүүлж буй ААН нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж сар бүр тайлан гаргаж, захиалагчтай уулзалт хийн, тэмдэглэл хөтлөн ажилласан байна.

Өмнөх жилүүдэд хэрэгжиж, 2023 онд үнийн өсөлтийн зөрүү авсан болон он дамжин хэрэгжиж буй барилга угсралт, их засварын ажилд зураг төсөл зохиогчтой гэрээ байгуулан зохиогчийн хяналтын хэрэгжүүлж, гэрээний дагуу санхүүжилт олгосон байна.

Аймгийн хэмжээнд ГХБХГ, БЗОСК ОНӨҮГ захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд захиалагчийн дотоод аудит гэсэн бүтэцгүй байна.

Б.3. Хэрэгжиж дууссан ашиглалтад хүлээлгэн өгсөн ажлын 63 хувийг данс бүртгэлд тусгасан байна.

Өмнөх онуудад болон 2023 онд хэрэгжиж дууссан нийт 20 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ байна. Эдгээрээс 16 ажлыг нягтлан бодох бүртгэлд тусгаж доор ажлуудыг тусгаагүй байсанд данс бүртгэлд тусгуулах албан шаардлага бичигдлээ.

- Заамар сум ЕБС-ийн барилгын өргөтгөл гэрээний дүн 1,961.6 сая төгрөг
- Сэргэлэн сум соёл, спортын төвийн барилга гэрээний дүн 1,660.8 сая төгрөг
- Баруун чиглэлд авто замаас Аргалант сумын төв хүртэлх авто зам гэрээний дүн 7,124.1 сая төгрөг

Борнуур сум соёл, спортын төвийн барилгыг данс бүртгэлд тусгуулах албан шаардлагыг санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн.

2022 оноос өмнө хэрэгжсэн ажлуудад материалын үнийн зөрүү тооцсоноор гэрээний дүнд өөрчлөлт оруулан 2023 онд санхүүжилт олгосон. Иймд үнийн өсөлт тооцсон дүнгээр данс бүртгэлд тусгасан дүнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэн нийт 16 барилга байгууламж, их засвар, замын ажилд 4,543.9 сая албан шаардлага ОНӨГ-т бичсэн.

В. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна

В.1. Хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлууд зориулалтын дагуу ашиглагдаж байна.

Боловсролын сайдын багцаас тайлант хугацаанд санхүүжигдсэн 17 ажлаас 1 ажил нь тоног төхөөрөмж худалдан авалт, 10 ажил нь бүрэн хэрэгжиж дуусан, ашиглалтад орсон барилгууд байна. Үүнд: 13 сумын 357 багшийг зөөврийн компьютероор хангасан, мөн 160, 320, 920 хүүхдийн суудалтай 3 сургуулийн барилга, 100 хүүхдийн суудалтай 2 цэцэрлэг, 40, 50, 75 ортой хүүхдийн 3 дотуур байр ашиглалтад орсноос гадна 2 сургуулийн барилгад их засвар хийгджээ. Шинээр ашиглалтад хүлээлгэн өгсөн сургууль, цэцэрлэг, дотуур байр нь бүрэн хүчин чадлаар зориулалтын дагуу ашиглагдаж байна.

Соёлын сайдын багцаас эрх шилжин хэрэгжсэн 4 соёлын төв байгаагаас Баянжаргалан сумын соёлын төв төсөвт өртөг өөрчлөгдөн, магадлалын дүгнэлт гарсан 2024 онд хэрэгжиж дуусахаар гэрээ байгуулсан, Баянчандмань сумын соёлын төв 2022 онд,

Борнуур, Сэргэлэн сумдын төв 2023 оны 12 сард ашиглалтад орсон одоогоор үйл ажиллагаа хэвийн явуулж байна.

Өндөрширээт сумын эмнэлэг 2021 онд, Баянцогт сумын эмнэлэг 2022 онд ашиглалтад орсон зориулалтын дагуу үйл ажиллагаа явагдаж байна.

Зуунмод-Манзушир чиглэлийн хатуу хучилттай авто зам, Эрдэнэсант сумын төвийн авто зам 2021 онд, Зуунмод сумын төвөөс Хөшгийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам 2022 онд, баруун чиглэлд авто замаас Аргалант сумын төв хүртэлх авто зам 2023 оны 9 дүгээр сард ашиглалтад орж, замын зорчих хөдөлгөөн хэвийн явагдаж байна.

В.2. Хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээнүүд тэргүүлэх ач холбогдол бүхий төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжиж 2021-2023 онуудад ашиглалтад хүлээлгэн өгсөн 20 барилга байгууламж, их засвар, замын ажил байна. Эдгээр төсөл арга хэмжээг анх төлөвлөсөн болон хүрсэн үр дүнд харьцуулж үзэхэд:

- Боловсролын салбарын хувьд сургуулиуд 3 ээлжээр хичээллэдэг байсан бол 2 ээлжээр хичээллэдэг болсон, анги танхимын хүрэлцээ нэмэгдэж сурах орчин сайжирсан, багш сурагчдын эрүүл ахуйн шаардлага хангагдсан, дотуур байрны хүрэлцээ нэмэгдэж боловсон 00, угаалтуур шүршүүртэй сурч амьдрах таатай нөхцөл бүрдсэн, цэцэрлэгийн хувьд анги танхимын хүртээмжгүй байдлаас шалтгаалж хамран суралцан хүүхдийг бүрэн хамруулж чаддаггүй байсан бол шинээр цэцэрлэг ашиглалтад орсноор хамрах хүүхдийн тоо нэмэгдэж стандартын шаардлага хангасан орчинд үйл ажиллагаа явуулдаг болсон зэргээр төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.
- Соёлын салбарын хувьд стандартын шаардлага хангасан дуу, хөгжим, бүжгийн заал, фитнесийн өрөө, номын сангийн уншигчдын танхим, орон нутаг судлах музей, үзэгчдийн болон спортын заалтай болж соёл, спортын дугуйлан, секцүүд ажиллаж хүүхэд, залуучуудыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлж, хөдөөгийн хүн амд соёл, спортын үйлчилгээ хүргэж байна.
- Шинэ эмнэлгүүд ашиглалтад орсноор иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжирч, эмч ажилтнуудын ажиллах орчин сайжирч, үйлчлүүлэгчид стандарт хангасан тав тухтай орчинд үйлчилгээ авдаг болсон байна.
- Авто замууд ашиглалтад орсноор тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал хангагдаж, иргэд, зорчигчдод эдийн засаг, цаг хэмнэхэд таатай нөлөө үзүүлэхээс гадна орон нутгийн аялал жуулчлал хөгжихөд зохих нөлөө үзүүлж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга, хэмжээнүүд нь аймаг, сумдын нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн, иргэд орон нутагт ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байна.

Аудитаар илэрсэн зөрчилд нийт 19,590.9 сая төгрөгийн 4 албан шаардлага бичиж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар улсын төсвөөс Төв аймагт 97,280.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31,970.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 32 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ эрх шилжин хэрэгжихээр батлагдсанаас 31 нь он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээ байна.
2. Өмнөх онуудад зарим төсөл арга хэмжээний санхүүжилтийг дөнгөж ажил эхлүүлэхээр тусгаснаас тухайн барилгын ажил гэрээний хугацаанд ашиглалтад орох боломжгүй, олон жил дамжин үргэлжлэх, хуулиар батлагдсан төсөвт өртөгт өөрчлөлт орж, гүйцэтгэгчтэй нэмэлт гэрээ байгуулах зэрэг асуудал гарсан байна
3. Зуунмод сумын Орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажил, Дулааны станцын халаалтын 1, 2, 3, 4, 5, 6, 7 дугаар хэсгийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл ажил гэсэн Зуунмод сумын хувьд чухал ач холбогдол бүхий хоёр төсөл арга хэмжээ цаашид хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй байна.
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжиж 2021-2023 онуудад ашиглалтад хүлээлгэн өгсөн барилга байгууламж, их засвар, замын ажлууд нь төлөвлөсөн үр дүнд хүрч аймаг, сумын нийгэм, эдийн засагт ач холбогдолтой төсөл арга хэмжээ болсон байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлд үндэслэн Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, ХБТХОХ-ийн дарга Д.Саран-Эрдэнэ нарт зөвлөх нь:

- Зуунмод сумын Орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажил, Дулааны станцын халаалтын 1, 2, 3, 4, 5, 6, 7 дугаар хэсгийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Тайлан хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Аудитын менежер О.Амаржаргал

Тайлан бичсэн:

Ахлах аудитор Л.Жаргалсайхан

Аудитор Ч.Загдсүрэн

Холбогдох байгууллагын санал:



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

41111 Төв аймаг, Зуунмод сум, Номт 1 дүгээр баг
Утас: 70273623, И-мэйл: tuv_zdtg@tov.gov.mn

2024. 04. 19 № 09/727

танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Гүйцэтгэлийн аудитын тайлантай холбогдуулан саналгүй учир тайлангийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж хамтран ажиллах болохоо үүгээр илэрхийлж байна.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.САРАН-ЭРДЭНЭ



4124020685



ТӨВ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

41111 Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272262, Факс: 70272192

2024.04.19 № 07/370
Тайлбар -ны № -т

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын
тайлантай танилцлаа.

Аудитын тайланд өгөх саналгүй болно.

ДАРГА

Б.НАСАНЖАРГАЛ

2024045
My doc: Toot A5



**ТӨВ АЙМАГ
БАРИЛГА ЗАХИАЛАГЧ ОРОН
СҮҮЦНЫ КОРПОРАЦИ ОНӨААТҮГ**

41100, Төв аймаг, Зүүнмод, сүм
Утас: 70272840

2024. 04.17 № 118
төрийн аудитын газрын №

**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцсан болно.

Холбогдох санал байхгүй болно.

ЗАХИРАЛ



Ж.БАТТӨГС

4124000174

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн

Аудитын код: ТӨАГ-2024/18-18-ШТА-ГА

Байгууллагын нэр: Орон нутгийн өмчийн газар

№	Аудитын чиглэл/асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (Мянган төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгадагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
A	1	3	4	5	6	7
1	Б.3. Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан уу?	Барилга, байгууламж ашиглалтад хүлээн авах комиссын актаар хүлээн авсан 14,518.2 сая төгрөгийн 4 барилга, байгууламжийг данс бүртгэлд тусгаагүйгээс 2,471.6 сая төгрөгийн Борнуур сумын соёлын төвийн барилгыг санхүүгийн тайлангийн аудитаар данс бүртгэлд тусгах албан шаардлага өгсөн, 12,046.6 сая төгрөгийн 3 барилга, байгууламжийг данс бүртгэлд тусгаагүй байна. Үүнд: Заамар сумын 320 хүүхдийн сургуулийн барилга-1,961.6 сая төгрөг, Сэргэлэн сумын соёлын төв-1,660.9 сая төгрөг, Аргалант сумын авто зам /7.1 км/-8,424.1 сая төгрөг	12,046.6	Хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, зөрчлийг арилгах албан шаардлага	хүлээн зөвшөөрсөн	Албан шаардлага өгөх
2		Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн барилга, байгууламжид УИХ-ын 2021 оны 88, 2022 оны 72 дугаар тогтоолын дагуу үнийн өсөлт тооцсон 24 барилга, байгууламжийн үнийн өсөлтийн зөрүүг данс бүртгэлд тусгаагүй	4,513.1	Данс бүртгэл дэх барилгын үнэ дээр нэмж тусгах албан шаардлага	хүлээн зөвшөөрсөн	Албан шаардлага өгөх
		Нийт дүн	16,559.7			

Бэлтгэсэн:

Ахлах аудитор
Аудитор

Л.Жаргалсайхан
Д.Загдсүрэн

Аудитын менежер

Анхан шатанд хянасан:

О.Амаржаргал

Танилцаж зөвшөөрсөн:


Орон нутгийн өмчийн газрын дарга
Өмчийн бүртгэл, ашиглалт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн

О.Амаржаргал

Хоёр дахь шатанд хянасан:

Тэргүүлэх аудитор

Ц.Хишигжаргал





ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 сарын 26 өдөр

Дугаар _____

155-A1970402-ТӨАГ-2024/18-18-ШТА-ГА

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын Их Хурлын 2021 оны 88, 2022 оны 72 дугаар тогтоолын дагуу үнийн өсөлт тооцсон 24 барилга, байгууламжаас “барилга, байгууламж ашиглалт оруулах комиссын дүгнэлт”-ээр ашиглалтад орсон 16 барилгын 4,513.1 сая төгрөгийн үнийн өсөлтийн зөрүүг данс бүртгэлд тусгаагүй байна. /Хавсралт 1/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.4.6-д “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу шийдвэрлэнэ”, 5.5.1-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үнийн өсөлтийн зөрүү авсан 16 барилга, байгууламжийн данс бүртгэл дэх үнийг 4,513.1 сая төгрөгөөр нэмж бүртгэн, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 20-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

019040714

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Батжаргал, ахлах мэргэжилтэн Г.Уранцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

Ч.ЗАГДСҮРЭН

№	Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний нэр	Төсвийн хуулийн заалт	Үнийн зөрүү
1	Сургуулийн барилга 920 суудал /Төв, Батсүмбэр сум/	X.1.1.47	946,227,078.0
2	Сургуулийн барилга, 160 суудал /Төв, Дэлгэрхаан сум/	X.1.1.104	227,200,000.0
3	Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар /Төв, Аргалант сум/	X.1.2.7	196,100,000.0
4	Хичээлийн А байрын барилгын их засвар /Төв, Зуунмод сум, Хүмүүн цогцолбор сургууль/	X.1.2.3	254,700,000.0
5	Сургуулийн дотуур байрын барилга, 40 ор /Төв, Архуст сум/	X.1.1.164	102,200,000.0
6	Дотуур байрын барилга, 50 ор /Төв, Баянхангай сум/	X.1.1.175	199,700,000.0
7	Сургуулийн дотуур байрын барилга, 75 ор /Төв, Мөнгөнморьт сум/	X.1.1.165	114,900,000.0
8	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Төв, Баянжаргалан сум/	X.1.1.184	85,400,000.0
9	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Төв, Эрдэнэсант сум/	X.1.1.91	112,700,000.0
10	Соёлын төвийн барилга /Төв, Баянчандмань сум/	XI.1.26	323,900,000.0
11	Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Төв, Архуст сум/	III.2.1	45,500,000.0
12	Эмнэлгийн барилга, 15 ор /Төв, Баянцогт сум/	XV.1.39	199,200,000.0
13	Эрүүл мэндийн төвийн барилга /Төв, Өндөрширээт сум/	XV.1.37	259,900,000.0
14	Зуунмод-Манзушир чиглэлийн хатуу хучилттай авто зам, 7км /Төв, Зуунмод сум/	XII.1.1.40	498,100,000.0
15	Сумын төвийн авто зам 3.2 км /Төв, Эрдэнэсант сум/	XII.1.1.14	55,700,000.0
16	Зуунмод сумын төвөөс Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам /Төв, Зуунмод сум/	XII.1.1.48	891,700,000.0
	НИЙТ		4,513,127,078.00



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар _____

156-A1970402-ТӨАГ-2024/18-18-ШТА-ГА

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Барилга, байгууламж ашиглалтад хүлээн авах комиссын дүгнэлтээр хүлээн авсан Заамар сумын 320 хүүхдийн сургуулийн барилга 1,961.6 сая төгрөг, Сэргэлэн сумын соёлын төв 1,660.9 сая төгрөг, Аргалант сумын 7.1 км авто зам 8,424.1 сая төгрөг, нийт 12,046.6 сая төгрөгийн барилга, байгууламжийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.4.4-т "Захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгөөр тус тус бүртгэн санхүүгийн тайландаа тусгана.", 5.4.6-д "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу шийдвэрлэнэ", 5.5.1-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх 12,046.6 сая төгрөгийн 3 барилга, байгууламжийг холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгаж, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 20-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Батжаргал, ахлах мэргэжилтэн Г.Уранцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

Ч.ЗАГДСҮРЭН

АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

Аудитын нэр: Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн
Аудитын код: ТӨАГ-2024/18-18-ЦТА-ГА
Байгууллагын нэр: Аймгийн БЗОСК ОНӨААТҮГ

№	Аудитын чиглэл/ асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (сая төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
A	1	2	3	4	5	6
1	Б.1. Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь, холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлсэн үү?	Борнуур сумын соёл, спортын төвийн барилга 2023 оны 12 сард хүлээлгэн өгсөн, зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн хэдий ч дотор заалны акустик хавтан хийгдээгүй, гадна тохижилтын ажил хийгдээгүй байхад санхүүжилт олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 ¹ -д заасныг болон Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баглагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3.2.6 ² , 4.3.1 ³ -д заасныг зөрчсөн.	30.5	Албан шаардлага	2023 оны 12 дугаар сарын 19-нд Борнуур сумын соёл, спортын төвийн барилга угсралтын ажлыг үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээж авсан. Тус комиссын шийдвэрт дотор заалны акустик хавтан болон гадна тохижилтын ажлыг дулааны улиралд хийхээр шийдвэрлэсэн.	Албан шаардлага
		Сэргэлэн сумын соёл, спортын төвийн барилга 2023 онд ашиглалтад орсон. Тус барилгын дотор халаалтын зургийг зохиогчтой зөвшилцөн өөрчилсөн, заалны урлагийн тайзны зургийг ашиглагчийн саналаар өөрчилсөн боловч захиалагчийн зөвшөөрлийг аваагүй, өөрчилсөн зургийн	71.6	Албан шаардлага	Сэргэлэн сумын соёл, спортын төвийн барилгын дотор халаалтын угсралт 2022 онд хийгдсэн, 2023 оны 10-р сард гүйцэтгэгч болон зургийн авторыг байлцуулан өөрчлөлтийн	Албан шаардлага

¹ Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

² 2.3.2.6 төслийн санхүүжилт хүссэн гүйцэтгэлд ирүүлж буй холбогдох баримт бичиг, мэдээллүүдийн иж бүрлэл, үнэн зөв эсэхэд бүрэн харнушага хүлээнэ

³ Захиалагч их засварын ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон их засварын ажлын календарьчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр илэрхийлсэн байдлаар гаргаж, энэ журмын хавсралт №8 болон №9-д заасан маягтын дагуу гаргана

	дагуу төсөв хийж хянуулаагүй нь Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 ⁴ , 40.1.17 ⁵ -г зөрчсөн			зураг төсөв хийхийг үүрэг болгосон. Төсөв гараагүй учраас зөрүү тооцох боломжгүй. Заалны тайзны шалыг ашиглагчийн хүсэлтээр төсөвт багтаан өөрчилсөн гэсэн тайлбарыг гүйцэтгэгч байгууллагаас өгсөн.
--	--	--	--	--

Бэлтгэсэн:  Л.Жаргалсайхан Огноо: 2024.04.15

Ахлах аудитор

Анхан шатанд хянасан:  Огноо: 2024.04.14

Аудитын менежер О.Амаржаргал

Хоёр дахь шатанд хянасан: 

Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал Огноо: 2024.04.15

Танилцаж зөвшөөрсөн.

Захирал  Ж.Баттөгс

Ерөнхий инженер  Л.Төр

Хяналтын инженер  Т.Хишигдорж

Огноо: 2024.04.15

⁴ 40.1.2.барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх

⁵ Барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн бол гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулах



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 сарын 26 өдөр

Дугаар

160-A1960398-ТӨА-2024/18-18-ШТА-ГА

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Борнуур сумын соёл, спортын төвийн барилга 2023 оны 12 сард хүлээлгэн өгсөн, зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн хэдий ч 30.5 сая төгрөгийн дотор заалны акоустик хавтан хийгдээгүй, гадна тохижилтын ажил хийгдээгүй байхад санхүүжилт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.3.2.6-д "төслийн санхүүжилт хүссэн гүйцэтгэлд ирүүлж буй холбогдох баримт бичиг, мэдээллүүдийн иж бүрдэл, үнэн зөв эсэхэд бүрэн хариуцлага хүлээнэ", 4.2.4-д "Захиалагч барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон барилга угсралтын ажлын календарьчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр илэрхийлж, энэ журмын холбогдох хавсралтад заасан маягтын дагуу гаргана" гэж заасныг тус тус зөрчсөн

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.-т "Аудитын баг аудитын алдаа, зөрчлийг үнэлж, албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох шийдэл гаргахдаа дараах нөхцөлийг харгалзана...", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй ажиллах,
2. Борнуур сумын соёл, спортын төвийн барилгын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэн, дутуу хийгдсэн ажлыг бүрэн гүйцэтгүүлж, 2024 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хариу мэдэгдэхийг аймгийн БЗОСК ОНӨААТҮГ-ын захирал Ж.Баттөгс, хяналтын инженер Г.Хишигдорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

Л.ЖАРГАЛСАЙХАН

019040702



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар _____

159-A1960398-ТӨА-2024/18-18-ШТА-ГА

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Сэргэлэн сумын соёл, спортын төвийн барилгын дотор халаалтын зургийг зохиогчтой зөвшилцөн өөрчилсөн /60.7 сая төгрөг/, заалны урлагийн тайзны зургийг ашиглагчийн саналаар өөрчилсөн /10.9 сая төгрөг/ боловч захиалагчийн зөвшөөрлийг аваагүй, өөрчилсөн зургийн дагуу төсөв хийж хянуулаагүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д "Барилгын ажил гүйцэтгэгч дараах чиг үүрэгтэй", 40.1.2-д "барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх", 40.1.17-д "барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн бол гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулах", Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.3.2-д "Захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 2.3.2.1-д "төслийн гүйцэтгэлийг барилга байгууламжийн болон норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл, төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл нэг бүрээр тулган шалгаж, хянан баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.-т "Аудитын баг аудитын алдаа, зөрчлийг үнэлж, албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох шийдэл гаргахдаа дараах нөхцөлийг харгалзана...", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй ажиллах,
2. Сэргэлэн сумын соёл, спортын төвийн барилгын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлж, зураг өөрчилсөн ажлуудын төсвийг гаргуулан хянаж баталгаажуулан 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг аймгийн БЗОСК ОНӨААТҮГ-ын захирал Ж.Баттөгс, Ахлах инженер Л.Төр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

Л.ЖАРГАЛСАЙХАН

019040699

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ТӨА-2024/18-18-ШТА-ГА

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал Утас: 70273463
Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Ахлах аудитор Л.Жаргалсайхан Утас: 70273465
Цахим хаяг: jargalsaikhanl@audit.gov.mn
Аудитор Ч.Загдсүрэн Утас: 70272582
Цахим хаяг: zagdsurench@audit.gov.mn
Аудитор Б.Одбилэг Утас: 70272582
Цахим хаяг: Odbilegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	3
А. Аймгийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээтэй нийцээгүй ажлын зураг төсөв нь магадлалын дүгнэлтээр баталгаажаагүй зарим төсөл арга хэмжээ тусгагдсан байна.....	5
<i>А.1 Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээ, хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээтэй нийцээгүй байна.....</i>	<i>5</i>
<i>А.2 Хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан зарим барилга байгууламжийн ажлын зураг төсөв нь магадлалын дүгнэлтээр баталгаажаагүй байхад төсөвт тусгаан хэрэгжүүлсэн байна.....</i>	<i>6</i>
<i>А.3 Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж байгаа боловч, зарим зөрчил илэрч байна.....</i>	<i>7</i>
Б. Аймгийн хөрөнгө оруулалтын 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан дийлэнх төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хүлээн авсан байна.....	9
<i>Б.1. Аймгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас 2 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 2 ажил дутуу хэрэгжсэн, бусад ажлууд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжсэн байна.</i>	<i>9</i>
<i>Б.2. Төсөл, арга хэмжээнд холбогдох хяналтыг хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан байна.....</i>	<i>10</i>
<i>Б.3. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгож байгаа хэдий ч зарим зөрчлүүд илэрсэн.</i>	<i>10</i>
В. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.11	11
<i>В.1. Аймгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.</i>	<i>11</i>
<i>В.2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжсэн ажлуудаас 2 төсөл, арга хэмжээнээс бусад ажлуудыг данс бүртгэлд бүрэн тусгасан байна.....</i>	<i>11</i>
<i>В.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу ашиглаж байна. 12</i>	<i>12</i>
ДҮГНЭЛТ: 13	13
ЗӨВЛӨМЖ: 14	14
Холбогдох байгууллагын санал:	15

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
БЗОСК	Барилга захиалагч, орон сууцны корпораци
БОХНСАХ	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар
БХТ	Барилгын хөгжлийн төв
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НӨАТ	Нэмүү өртгийн албан татвар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗУХ	Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс
ТӨХ	Тендерийн өгөгдлийн хүснэгт
ТШЗ	Тендер шалгаруулалтын зөвлөмж
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дах зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийлээ.

Аудитын зорилт

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх,
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх,
- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх

Аудитын хамарсан хүрээ

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар /орон нутгийн шилжих үлдэгдэл, авто замын сан/ хэрэгжсэн төсөл арга хэмжээг, төлөвлөж, хэрэгжүүлсэн, хяналт тавьж ажилласан аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын ХБТХОХ, СТСХ, ГХБХБГ, БЗОСК ОНӨААТҮГ, ОНӨГ, зэрэг байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагаа, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамрууллаа.

Аудитын хязгаарлалт

Байхгүй.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

- МУЕА-н баталсан Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөөнд тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд
- Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Аймгийн таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 02 дугаар тогтоол
- Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 01 дүгээр тогтоол
- Аймгийн ИТХ-ын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн “Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” 01 дүгээр тогтоол
- Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоол

- Аймгийн ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 02 дугаар тогтоол.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдаж, аудитын менежер О.Амаржаргал чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Ч.Загдсүрэн нар гүйцэтгэв. Аудитын талбарын ажлыг 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайлан, судалгааг 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдөр УАГ-т хүргүүллээ.

Хүндрэл бэрхшээл

А. Аймгийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээтэй нийцээгүй ажлын зураг төсөв нь магадлалын дүгнэлтээр баталгаажаагүй зарим төсөл арга хэмжээ тусгагдсан байна.

А.1 Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээ, хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээтэй нийцээгүй байна

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсөв баталж, 2023 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 02 дугаар тогтоолоор тодотгол хийгдсэн. Төсөв баталсан тогтоолын хавсралтаар аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсан байна. Үүнд:

- Хоёрдугаар хавсралтаар аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 6,115.0 сая төгрөгийн 6 барилга байгууламж, төсөл арга хэмжээний жагсаалтыг,
- Гуравдугаар хавсралтаар аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг 1,200.0 сая төгрөгийн 6 арга хэмжээ,
- Тавдугаар хавсралтаар аймгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх их засварын төсөл, арга хэмжээний жагсаалтыг 1,810.0 сая төгрөгийн 8 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан.
- Тодотгосон төлөвлөгөөгөөр аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар /шилжих үлдэгдэл/ 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл арга хэмжээний жагсаалтыг 8,906.7 сая төгрөгийн 16 төсөл арга хэмжээ болгон нэмэгдүүлэн баталжээ.

Аймгийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл арга хэмжээ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7¹, 4.1.10², 4.1.14³-д заасан хөгжлийн бодлогын дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй нийцсэн эсэхийг авч үзэхэд:

- Төсвийн тодотгол баталсан тогтоолын 1 дүгээр хавсралтын жагсаалтын 4-д Татварын хэлтэс болон 5 сумын автомашин шинэчлэх зардалд 165.0 сая төгрөг баталсан нь аймгийн хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд огт тусгаадаагүй,
- Жагсаалтын 15-д бусад зардал гэж 425.9 сая төгрөг баталсан,
- Жагсаалтын 10-д Сүмбэр сумын зам болон бусад шинээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсөв хийлгэх зардалд 79.1 сая төгрөг баталсан нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.2.1, 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 5.1.2-н 153-д тусгагдсан зорилт арга хэмжээтэй нийцээгүй зэрэг асуудал байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д "Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх

¹ "Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт суурилсан орон нутгийн онцлогийг тусгасан дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг

² "Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийн баримт бичгийг

³ "Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө" гэж Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан, тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг

хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт ... аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, орон нутгийн төсөв хамаарна", 6.10.4-д "Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Мөн аймгийн ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн "Эрэмбэлсэн дараалал шинэчлэн батлах тухай" 02 дугаар тогтоол батлагдаж, тогтоолын 2 дугаар заалтаар сумдын төсөвт байгууллагын барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, их засвар хийх эрэмбэ дарааллыг баримтлан хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган улсын болон орон нутгийн төсөв, гадаад, дотоодын байгууллагын төсөл, хөтөлбөрт хамруулах замаар барилга, байгууламжийн засвар, шинэчлэлийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасан байна. Эрэмбэ тогтоох жагсаалтыг шинээр ашиглалтад орсон барилга, шинээр барих барилга, өргөтгөл барих барилга, их засвар хийх барилга гэж ангилсан байна.

Аймгийн хөрөнгө оруулалтын 2023 оны жагсаалтад батлагдсан өргөтгөл, их засварын ажлыг дээрх эрэмбэлсэн дараалалд хэрхэн тусгагдсаныг тулган шалгахад:

- Алтанбулаг сумын ЭМТ-н барилга өргөтгөл хийх эрэмбэлсэн дарааллын 3-т тусгагдан 2022 онд аймгийн төсвөөс 150.0 сая төгрөг санхүүжилт батлагдан олгогдсон, харин их засварын 18-д тусгагдсан байхад 2023 онд 300.0 сая төгрөг баталсан,
- Борнуур сумын цэцэрлэгийн барилгад 2016 он дээврийн засвар, 2021 онд ариун цэврийн байгууламж, дотор халаалтын шугам хийгдсэн, их засварын жагсаалтын 12-т тусгагдсан байхад 100.0 сая төгрөг батлагдсан,
- Сэргэлэн сумын ЕБС 2019 онд 300.0 сая, 2021 онд 50.0 сая төгрөгийн засвар хийгдсэн, их засварын жагсаалтын 34-т тусгагдсан байхад 350.0 сая төгрөг баталсан,
- Баянцагаан сумын ЗДТГ-ын барилга их засварын жагсаалтын 8-д тусгагдсан, өмнөх 7 сумын ЗДТГ-ын барилгын их засвар хийгдээгүй 2023 онд 156.0 сая төгрөг батлагдсан,
- Аймгийн ЗДТГ-н 1,506.4 сая төгрөгийн их засвар нь эрэмбэ дараалалд огт тусгаадаагүй байна.

Эндээс үзэхэд аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалт батлахад дээрх эрэмбэлсэн дараалал тогтоосон тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна.

А.2 Хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан зарим барилга байгууламжийн ажлын зураг төсөв нь магадлалын дүгнэлтээр баталгаажаагүй байхад төсөвт тусган хэрэгжүүлсэн байна.

Аймгийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан хөрөнгө оруулалтын чанартай төсөл, арга хэмжээнүүдийн хувьд зураг төсөл, ажлын даалгавар холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэхийг үзэхэд дараах зөрчил илэрсэн:

- Баянцагаан сумын гэр хорооллын айл өрх, үйлчилгээний байгууллагуудыг нэгдсэн халаалтын системд холбох ажлын зураг төсөв нь магадлалын дүгнэлтээр батлагдаагүй.
- Заамар сумын ЭМТ-ийн өргөтгөлийн ажлын зураг төсөв хийгдэж, магадлалын дүгнэлтээр баталгаажаагүй байхад төсөвт тусган баталсан.
- Алтанбулаг сумын ЭМТ-ийн барилгын өргөтгөлийн зураг, төсөв нь хийгдээгүй байхад төсөвт тусгаж баталсан, худалдан авах ажиллагаа явагдаж, гэрээ байгуулагдсаны дараа магадлалын дүгнэлт гарсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁴, 29¹.2.2⁵ болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3⁶-д заасныг зөрчсөн байна.

Бусад төсөл арга хэмжээний хувьд зураг төсөл, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт хийгдсэн байна.

А.3 Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж байгаа боловч, зарим зөрчил илэрч байна.

Аймгийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан 32 төсөл, арга хэмжээнээс хөрөнгө оруулалтын бус арга хэмжээнүүд, хэрэгжээгүй ажлуудаас бусад 22 төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагааны хууль тогтоомжоор гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Худалдан авах ажиллагааг ил тод, хуулийн дагуу зохион байгуулсан байдлыг шалгахад дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд 2022 онд 800.0 сая төгрөг, 2023 онд 800.0 сая төгрөг батлагдсан, тендер шалгаруулалт 2022 онд явагдаж Төв цогт өлзийт ХХК шалгарсан. Захиалагчаар БЗОСК ОНӨААТҮГ томилогдож худалдан авах ажиллагааны захиалга /түрээсийн орон сууц хэрэгжүүлэх ажлын сонгон шалгаруулалтын урилга 2022.04.11/ өгөхдөө 40 айлын орон сууцны барилга болгон өөрчилж, төсөвт өртгийг 3,000.0 сая болгон өөрчилсөн байна. Аймгийн ИТХ-аар баталсан төсөвт өртгийг өөрчилсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8⁷ болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4⁸ заасныг, орон сууцны барилга болгон өөрчилсөн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29¹.2.2 болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-д заасныг тус тус зөрчсөн байна. Мөн Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2-т “Төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага”, 3.2.2.2-т “Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх гэснийг хангаагүй байна.
- Энэ ажлын үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 16-нд байгуулж, 5 дугаар сарын 30-нд бүрэлдэхүүнд нь өөрчлөлт оруулсан. Үнэлгээний хороо 2022 оны 4 дүгээр сарын 21-нд тендер зарлаж, 5 дугаар сарын 25-нд нээлт хийж, 30-нд хуралдаж дүгнэлт гаргасан байна, Тус тендерт ганц оролцогч буюу Төв цогт өлзийт ХХК-г шалгаруулжээ. Тендерийн баримт бичигт төсөвт өртгийг 3,000.0 сая төгрөг гэсэн байхад тус компани 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 01/29 тоот албан бичгээр 3,867.7 сая төгрөгийн үнийн санал, 01/30 тоот албан бичгээр 1 мкв-ын үнийн санал НӨАТ орсон 1.9 сая төгрөг /нийт 1952.2 мкв 1.9 сая төгрөгөөр тооцоход 3,709.2 сая төгрөг/ гэж өгчээ. Тендерийн баримт бичигт тусгагдсан төсөвт өртгөөс хэтэрсэн, ирүүлсэн 2 үнийн санал нь зөрүүтэй байхад үнэлгээний хороо шалгаруулсан байна. Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл буюу дүгнэлтэд нарийн бичгээр ажилласан ОНӨГ-ын мэргэжилтэн хууль зөрчсөн гэж үзэн татгалзсан, бусад гишүүд гэрээ байгуулах эрх олгохыг дэмжсэн байна. Тендерийн баримт бичигт тусгагдсан шаардлагыг

⁴ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁵ 29¹.2.2.барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

⁶ 13.3.3.техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ

⁷ 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

⁸ 46.1.4.худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах;

шалгарсан компани хангасан эсэхийг шалгаж үзэхэд, тендерийн баримт бичгийн ТӨХ-ийн ТШЗ 17.6.1-д тусгай зөвшөөрөл ЗТ-3.1 шаардана, ТШЗ 17.6.3-д ажил гүйцэтгэхэд ашиглах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд "Бульдозер" шаардана гэсэн байхад Төв цогт өлзийт ХХК-н ирүүлсэн тендерийн баримт бичигт дээрх тусгай зөвшөөрөл байхгүй, техник хэрэгсэлд бульдозер байхгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4⁹-д заасныг зөрчсөн, өөрөөр хэлбэл шаардлага хангаагүй компанийг шалгаруулж үнэлгээний хороо холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн байна.

- Аймгийн БОХНСАХ-ий зардалд батлагдсан 300.0 сая төгрөгийн санхүүжилттэй "Аймгийн төвийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажил"-ыг Зуунмод суманд эрх шилжүүлсэн байна. Тус цэцэрлэгжүүлэлтийн ажлыг 16 хувааж, Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-аас ирүүлсэн төсвөөр сумын Засаг дарга шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлжээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1¹⁰, 48 дугаар зүйлийн 48.2¹¹, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.3¹²-т заасныг тус тус зөрчсөн байна.
- Алтанбулаг сумын ЭМТ-ийн барилгын өргөтгөлийн ажлыг зураг, төсөв нь магадлалаар баталгаажаагүй байхад худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчтэй 822.9 сая төгрөгийн гэрээ байгуулсны дараа зураг, төсөв 793.5 сая төгрөгөөр БХТ-ийн магадлалаар баталгаажсанаар 29.4 сая төгрөгийн зөрүү гарчээ.

Алтанбулаг сумын ЭМТ-ийн барилга, БОХНСАХ-ий зардалд батлагдсан 300.0 сая төгрөгтэй холбоотой зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29¹.2.2¹³ болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-д заасныг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1¹⁴, 48 дугаар зүйлийн 48.2¹⁵ -т заасныг тус тус зөрчсөн байна.

⁹ 27.4.Энэ хуулийн 27.3-т зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж захиалагч уг тендерээс татгалзана

¹⁰ Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ: 7.1.5.энэ хуулийн 4.1.10-т заасан этгээд; /4.1.10."захиалагчаас хараат этгээд" гэж дараах нөхцөлийн аль нэгд хамаарах этгээдийг: 4.1.10.а.тухайн хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын бүрэлдэхүүнийг захиалагч томилж, чөлөөлдөг; 4.1.10.б.захиалагч нь тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлдог, эсхүл тодорхойлоход оролцдог./, 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно

¹¹ "Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:", 48.2.1-т "худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах

¹² "Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл эрх хүлээн авсан этгээд нь төслийг батлагдсан төсөвт өртөгт багтаан худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах үүрэгтэй", 4.1.32-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй хөрөнгө оруулалтын төслийг төсвөөс санхүүжүүлэхийг хориглоно"

¹³ 29¹.2.2.Барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

¹⁴ 7.1 Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ: 7.1.5.энэ хуулийн 4.1.10-т заасан этгээд; /4.1.10."захиалагчаас хараат этгээд" гэж дараах нөхцөлийн аль нэгд хамаарах этгээдийг: 4.1.10.а.тухайн хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын бүрэлдэхүүнийг захиалагч томилж, чөлөөлдөг; 4.1.10.б.захиалагч нь тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлдог, эсхүл тодорхойлоход оролцдог./, 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно"

¹⁵ 48.2 "Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:", 48.2.1-т "худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах", Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл эрх хүлээн авсан этгээд нь төслийг батлагдсан төсөвт өртөгт багтаан худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах үүрэгтэй", 4.1.32-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад

Б. Аймгийн хөрөнгө оруулалтын 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан дийлэнх төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хүлээн авсан байна.

Б.1. Аймгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас 2 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 2 ажил дутуу хэрэгжсэн, бусад ажлууд төлөвлөсөн хугацаанд хэрэгжсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл арга хэмжээнээс хөрөнгө оруулалтын чанартай бус гамшгийн эрсдэлийг бууруулах, гадаад арга хэмжээ, аймаг хөгжүүлэх санд төвлөрүүлэх, бусад зардал гэх мэт арга хэмжээ болон хэрэгжээгүй арга хэмжээг хасаж тооцвол 2023 онд 22 арга хэмжээ хэрэгжсэн байна. Эдгээрээс дараах төсөл арга хэмжээний хувьд зөрчил илэрсэн.

- Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд орон нутгийн төсөвт 2022 онд батлагдсан 800.0 сая, 2023 он батлагдсан 800.0 сая төгрөг, нийт 1,600.0 сая төгрөгийг Төв цогт өлзийт ХХК-д олгожээ. Тус компанитай 2022 оны 6 дугаар сарын 30-нд 40 айлын орон сууц 3,867.7 сая төгрөгөөр барих гэрээ байгуулсан /гэрээний дуусах хугацаа 2023 оны 9 дүгээр сарын 30/, 2023 оны 12 дугаар сарын 22-нд нэмэлт гэрээ болгон өөрчлөлт оруулсан. Гэрээний үлдэгдэл санхүүжилтийг аймгийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх боломжгүй болсон тул 1 мкв-г 2.0 сая төгрөгөөр тооцон нийт 800 мкв талбайд ноогдох 18 ширхэг орон сууц авахаар болгож нэмэлт гэрээ байгуулжээ. Аймгийн орон сууцны зөвлөл /аймгийн Засаг даргын орлогч, ХБТХО-ын хэлтсийн дарга, ОНӨГ-ын дарга, БЗОСК ОНӨААТҮГ-ын захирал, хяналтын инженер, Төв цогт өлзийт ХХК-ын захирал гэсэн бүрэлдэхүүнтэй/ 2023 оны 11 дүгээр сарын 31-ны өдөр хуралдаж, 1,600.0 сая төгрөгт 1 мкв-г 2.0 сая төгрөгөөр тооцон нийт 800 мкв орон сууц авахаар шийдвэрлэсэн байна. Төв цогт өлзийт ХХК-аас 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр захиалагч байгууллагад хүсэлт гаргаж, улмаар аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн а/818 тоот захирамж гарч, гэрээнд өөрчлөлт оруулжээ. Орон сууцны зөвлөлийн хурлын тэмдэглэлд гүйцэтгэгч компанийн тендерт санал болгосон үнэ 1 мкв нь 2.0 сая төгрөг гэж танилцуулагдаж дээрх шийдвэрүүд гарсан байна. Гэтэл Төв цогт өлзийт ХХК нь тендерт оролцоходоо буюу 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 01/30 албан бичгээр 1 мкв-ын үнэ 1.9 сая төгрөг, НӨАТ-ын 10 хувь багтсан үнэ гэж үнийн санал хүргүүлж улмаар тендерт шалгарсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-д "Шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь тендерийн үнэ байна" гэж заасан байтал тендерт санал болгоогүй үнээр тооцож гэрээнд нэмэлт оруулж материалын үнийн зөрүү гэж 2.0 сая төгрөг болгон өөрчилж, 80.0 сая төгрөгийн зөрүүг гүйцэтгэгчид олгосон зөрчилд албан шаардлага бичив.
- Аймгийн төвийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажил"-ыг гүйцэтгэсэн Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын тус бүр 18.8 сая төгрөг, нийт 37.7 сая төгрөгийн гэрээтэй 2 ажил буюу Одонт хөтлөөс Хаан банк хүртэл 48 ширхэг цэцгийн сав хийж, цэцэг тарих ажлын төсөвт цэцгийн савыг цутгаж хийхээр байсныг өөрчилж хийхдээ төсөвт өөрчлөлт оруулалгүй гүйцэтгэлийг гаргаж санхүүжсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.12-т "Төслийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох", 4.1.33-т "Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно" гэсэн заалтууд зөрчигдсөн байна
- Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн цахим засаглал хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 20.0 сая төгрөгт тоног төхөөрөмж худалдан авах, 20.0 сая төгрөгт Цахим Төв

хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй хөрөнгө оруулалтын төслийг төсвөөс санхүүжүүлэхийг хориглоно"

гэсэн аппликэйшн нээх буюу зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулагджээ. Цахим аппликэйшнд зар мэдээлэл, өргөдөл гомдол, санал асуулга, Төв аймгийн нийтийн тээврийн үйлчилгээ, хэлтэс агентлагийн мэдээлэл байрших бөгөөд төрийн байгууллагуудын мэдээлэл дутуугаас хүлээж аваагүй байна.

- Аргалант суманд орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээнд 2 удаа тендер зарласан боловч оролцогч оролцоогүй тул иргэд ААН байгууллагад санал хүргүүлсэн. Нэг иргэнээс өөрийн эзэмшлийн 24.24 кв, 29,14 кв бүхий 2 өрөөг 1.8 сая төгрөгөөр худалдах санал тавьсны дагуу гэрээ байгуулан худалдаж авсан байна. Тухайн байрыг орон сууцны зориулалтаар худалдан авсан боловч хөрөнгийн үнэлгээ хийлгээгүй, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг шилжүүлж аваагүй байна. Тухайн байрны чанар байдал, насжилт, зах зээлийн үнэ зэрэг нь тодорхойгүй тул зөрчлөөр бүртгэж хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэхээр албан шаардлага бичсэн.
- Заамар сумын ЭМТ-ийн өргөтгөлийн ажил 2023 онд хэрэгжиж дуусах гэрээтэй боловч зураг, төсөв хийсэн компани холбогдох байгууллагуудаас тенхикийн нөхцөл бүрэн гүйцэт аваагүйгээс ажил эхлэх үед газар доор дулааны шугам гарч дахин зураг төсөлд өөрчлөлт оруулсанаас ажил хойшилж тухайн онд багтаан дуусгах боломжгүй болсон байна.

Б.2. Төсөл, арга хэмжээнд холбогдох хяналтыг хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдаж хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийг ашиглалтад хүлээж авахад Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан журамд заасны дагуу комисс ажиллаж дүгнэлт гаргаж албажуулсан байна.

Харин аймгийн төвийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажлын гүйцэтгэлд захиалагч Зуунмод сумын ЗДТГ-аас хяналт хийгээгүй, ажлын үе шат бүрд зөрчлийг арилгаагүйгээс, цэцгийн сав хийх 37.7 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлд зөрчил гарсан байна.

Б.3. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгож байгаа хэдий ч зарим зөрчлүүд илэрсэн.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн.

- Аймгийн замын сангаас хэрэгжсэн Зуунмод сумын авто замын засвар, өвөл, зуны арчлалтын ажил 2.8 сая төгрөг, Зуунмод сумын дотор замын их засварт 2.9 сая төгрөг, нийт 5.7 сая төгрөгийг гүйцэтгэгч Төв АЗЗА ТӨХК-д илүү шилжүүлсэн,
- Зуунмод сумын ЗДТГ нь Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-т захиалагчийн зардлыг суутган тооцолгүй 1.3 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон, гэрээт ажлын төсөв болон гүйцэтгэлийн баримтад материалын зардалд хар шороог 3 янзын үнээр тооцож санхүүжсэний үнийн зөрүү 0.6 сая төгрөг, мөн Одонт хөтлөөс хаан банк хүртэл нийт 48 ширхэг цэцгийн сав модоор хийсэн бөгөөд ажлын төсөвт цэцгийн савыг цутгаж хийхээр байсныг өөрчлөлгүй хуучин төсвөөр гүйцэтгэлийг гаргаж санхүүжсэнээс 2.3 сая төгрөг, нийт 2.9 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон,
- Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын зураг, төсөв хийсэн зохиогчийн хяналтын зардалд 2.7 сая төгрөг илүү олгосон нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах,

тайлагнах журмын 2 дугаар зүйлийн 2.3.2.5¹⁶-д заасныг зөрчсөнд төлбөрийн акт тогтоосон.

- Эрдэнэсант сумын соёлын төвийн их засварын ажлын 466.3 сая төгрөгийн гэрээг 2023 оны 06 дугаар сарын 26-нд Юу зэт эрдэнэ ХХК-тай байгуулж, 6 дугаар сарын 30-нд 301.8 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг олгожээ. Тендерийн бичиг баримтад урьдчилгаа санхүүжилт олгохгүй гэж заасан боловч урьдчилгаа санхүүжилтэд нийт санхүүжилтийн 65 хувийг олгосон зөрчил илэрлээ. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 4 дүгээр зүйлийн 4.1.12¹⁷-т заасныг зөрчсөнд албан шаардлага бичлээ.

В. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

В.1. Аймгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын 2023 оны жагсаалтад батлагдаж хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээнүүд төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

- Түрээсийн орон сууц хөтөлбөрийн хүрээнд 18 айлыг орон сууцаар хангажээ.
- Багш бүрд компьютер төслийн хүрээнд 27 сумын ЕБС, цэцэрлэг, Зуунмод, Эрдэнэ, Баянчандмань, Заамар, сумын политехникийн коллеж, БШУГ зэрэг байгууллагуудыг 484 ширхэг зөөврийн компьютероор хангасан байна
- Ерөнхий боловсролын сургуулийн физикийн туршилтад хичээлийн иж бүрдэл нийлүүлэх хүрээнд Бүрэн, Жаргалант, Заамар, Лүн, Эрдэнэсант, Борнуур, Баянчандмань, Эрдэнэ, Зуунмод зэрэг сумын сургуульд тоног төхөөрөмж нийлүүлжээ.
- Алтанбулаг сумын ЭМТ, Эрдэнэсант сумын Соёлын төв, Борнуур сумын цэцэрлэг, Сэргэлэн сумын ЕБС, аймгийн ЗДТГ-ын их засварууд хийгдэж төрийн үйлчилгээ үзүүлэх орчин сайжирсан байна.
- Зуунмод, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Батсүмбэр, Алтанбулаг, Эрдэнэсант сумдын авто замын засвар, арчлалт, Зуунмод, Борнуур, Эрдэнэ сумдын дотор замын их засварын ажил, Зуунмод сумын Баянхошуу баг чиглэлийн авто зам шинэчлэлийн ажлууд хийгдэж замын зорчих хөдөлгөөний аюулгүй байдал сайжирсан байна.

В.2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагдан хэрэгжсэн ажлуудаас 2 төсөл, арга хэмжээнээс бусад нь нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээг ашиглагч байгууллагуудын данс бүртгэлд тусгасан байна. Доорх хоёр ажлыг данс бүртгэлд тусгаагүй байсанд албан шаардлага бичсэн. Эрдэнэсант сумын соёлын төвийн 466.3 сая төгрөгийн их засварын ажил, Зуунмод сумын 499.0 сая төгрөгийн Баянхошуу баг чиглэлийн авто зам, нийт 965.3 сая төгрөгийн 2 ажлыг данс бүртгэлд тусгаагүй тул албан шаардлага бичсэн.

¹⁶ 2.,3,2. 5барилга байгууламжийн зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт бичиг, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх

¹⁷ "Төслийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно: 4.1.12.1.тухайн төсөлд урьдчилгаа олгох талаар худалдан авах ажиллагааны баримт бичиг болон гэрээнд тусгасан байх; 4.1.12.2.урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулсан байх (Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Урьдчилгаа төлбөрийн баталгааны маяг"-ын дагуу гаргана); 4.1.12.3.банкны урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн санхүүжилтийг олгоход урьдчилгаа төлбөрийн банкны баталгааг банканд байршуулсан эсэх баримтыг санхүүжилт хүсэх баримтад хавсаргасан байх; 4.1.12.4.төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын улсын төсвийн санхүүжилтээр санхүүжих төслийн урьдчилгаа төлбөрийн нийт хэмжээ нь тухайн онд батлагдсан нийт санхүүжилтийн 30 хувиас ихгүй байна

В.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу ашиглаж байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын 2023 оны жагсаалтад батлагдан, хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээнүүдийн хувьд зориулалтын дагуу ашиглагдаж байна.

Алтанбулаг сумын ЭМТ, Эрдэнэсант сумын Соёлын төв, Борнуур сумын цэцэрлэг, Сэргэлэн сумын ЕБС, аймгийн ЗДТГ-ын их засварууд хийгдсэн зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж байна. Зуунмод, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Батсүмбэр, Алтанбулаг, Эрдэнэсант сумдын авто замын засвар, арчлалт, Зуунмод, Борнуур, Эрдэнэ сумдын дотор замын их засварын ажил, Зуунмод сумын Баянхошуу баг чиглэлийн авто зам шинэчлэлийн ажлууд хийгдэж ашиглалтад орсон. Бүрэн, Жаргалант, Заамар, Лүн, Эрдэнэсант, Борнуур, Баянчандмань, Эрдэнэ, Зуунмод зэрэг сумын сургуульд физикийн хичээлийн туршилтын иж бүрдэл, 27 сумын ЕБС, цэцэрлэг, Зуунмод, Эрдэнэ, Баянчандмань, Заамар, сумын политехникийн коллеж, БШУГ зэрэг байгууллагуудыг 484 ширхэг зөөврийн компьютерыг тус тус хүлээн авч данс бүртгэлд тусган үйл ажиллагаандаа ашиглаж байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүд болон аймгийн ИТХ-ын 2022 оны "Эрэмбэлсэн дараалал шинэчлэн батлах тухай" тогтоолд нийцээгүй зарим төсөл арга хэмжээ тусгагдсан байна.
- Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд зураг төсөв нь хийгдэж, магадлалын дүгнэлтээр баталгаажсан төсөл арга хэмжээг төсөвт тусгахаар заасан боловч бүрэн хэрэгжихгүй байна.
- Захиалагч байгууллага болох БЗОСК ОНӨААТҮГ нь түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг орон сууцны барилга болгон өөрчилж холбогдох хууль тогтоомжийг зөрчин сонгон шалгаруулалт явуулж гүйцэтгэгчийг шалгаруулсан, улмаар тендерт санал болгосон үнээс материалын үнийн зөрүү гэж 80.0 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгосон байна.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж аймгийн БОХНСАХ-ий зардалд батлагдсан 300.0 сая төгрөгийг 16 хувааж шууд гэрээ байгуулсан байна.
- Аймгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа, хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлүүд нь тухай асуудлыг хариуцсан төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, хариуцлагаас шалтгаалж байна

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлд үндэслэн Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Д.Саран-Эрдэнэд нарт зөвлөх нь:

- Зураг, төсөв нь хийгдэж, магадлалын дүгнэлтээр баталгаажсан, хуульд заасан зөвшөөрөл олгогдсон ажлыг хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтад тусгаж байх,
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалт гаргахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүд болон аймгийн ИТХ-ын 2022 оны “Эрэмбэлсэн дараалал шинэчлэн батлах тухай” тогтоолд нийцүүлж байх
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох

Зуунмод сумын захирагч Ч.Сарангэрэлд:

- Зуунмод сумын ЗДТГ нь ажил гүйцэтгэх гэрээ Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-тэй байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зарим заалтыг зөрчиж байгаа тул дээрх зөрчлийг арилгах.

Тайлан хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор

Аудитын менежер

Тайлан бичсэн:

Ахлах аудитор

Аудитор

Аудитор

Ц.Хишигжаргал

О.Амаржаргал

Л.Жаргалсайхан

Ч.Загдсүрэн

Б.Одбилэг

117144522
НЮА0064 9060464

Холбогдох байгууллагын санал:



**ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**

41111 Төв аймаг, Зуунмод сум, Номхон дугаар байр
Утас: 70273623, И-мэйл: tov_zdtg@tov.gov.mn

2024.06.07 № 07/1004


Тамгай _____ -ны № _____

**ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Гүйцэтгэлийн аудитын тайлантай холбогдуулан саналгүй учир тайлангийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж хамтран ажиллах болохоо үүгээр илэрхийлж байна.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА *[Signature]* Д.САРАН-ЭРДЭНЭ



4124021049



**ТӨВ АЙМАГ
БАРИЛГА ЗАХИАЛАГЧ ОРОН
СУУЦНЫ КОРПОРАЦИ ОНӨААТҮГ**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272840

2024. 06. 07 № 168

Тайлан № _____

**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцсан болно.

Холбогдох санал байхгүй болно.

ЗАХИРАЛ

Ж.БАТТӨГС



4104059270

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн

Аудитын код: ТӨАГ-2024/18-18-ШТА-ГА

Байгууллагын нэр: Зуунмод сумын ЗДТГ

№	Аудитын чиглэл/асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (Мянган төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
A	1	3	4	5	6	7
1	Худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, зохион байгуулж, шаардлага хангасан гүйцэтгэгч шалгаруулсан уу?	Аймгийн БОХНСАХ-ий зардалд батлагдсан 300.0 сая төгрөгийн санхүүжилттэй "Аймгийн төвийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажил"-ыг Зуунмод суманд эрх шилжүүлсэн байна. Тус цэцэрлэгжүүлэлтийн ажлыг 16 хувааж, Зуунмод цэцэрлэгжүүлэлт-ОНӨААТҮГ-аас ирүүлсэн төсвөөр сумын Засаг дарга шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлжээ. Энэ нь 7.1.Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ: 7.1.5.энэ хуулийн 4.1.10-т заасан этгээд, 4.1.10 "Захиалагчаас хараат этгээд" гэж дараах нөхцөлийн аль нэгд хамаарах этгээдийг: 4.1.10.а.тухайн хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын бүрэлдэхүүнийг захиалагч томилж, чөлөөлдөг, 4.1.10.б.захиалагч нь тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлдог, эсхүл тодорхойлоход оролцдог./, 10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно. 8.2.Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ: 48.2.1.худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах; Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.1.3.Төсвийн ерөнхийлөн захирагч,	300,000.0	албан шаардлага, /хариуцлага тооцох албан шаардлага/	Аймгийн 2023 оны төсөвт Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөнд 300.0 сая төгрөг тусгагдсан. 2023 онд аймаг сумын төсөвт "Зуунмод цэцэрлэгжүүлэлт"-ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны зардал нэгч төгрөг тусгагдаагүй. 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр "Зуунмод цэцэрлэгжүүлэлтийн албан конторт Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ю.Бямбацогт, Аймгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Д.Саранзүрэнэ, Зуунмод сумын засаг дарга Ч.Сарангэрэл, аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны улсын ахлах байцаагч А.Ариунбаяр мөн "Зуунмод цэцэрлэгжүүлэлт"-ОНӨААТҮГ-ын удирдах зөвлөлийн гишүүд Р.Баарсайхан, Б.Батжаргал, С.Мөнх-Амгалан, Н.Шинэбаяр, захирал Г.Жаргалцэцэг нар бүрэлдэхүүнтэй хуралдаж тухайн байгууллагат 2023 онд аймаг сумын төсвөөс хөрөнгө мөнгө тусгагдаагүй тул аймгийн 100 жилийн ойг угтаж аймгийн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөнд 300.0 сая төгрөгөөр "Зуунмод цэцэрлэгжүүлэлт"-ОНӨААТҮГ-аар Зуунмод хотын нийтийн гудамж талбайн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалт, өнгө үзэмжийг дээшлүүлэх 16-н нэр төрлийн ажлыг гүйцэтгүүлэн олгохоор хэлэлцэн шийдвэрлэсэн. Тухайн хурлын шийдвэрийн дагуу Зуунмод сумын ЗДТГ-аас 16 нэр төрлийн ажлын шууд гэрээг "Зуунмод цэцэрлэгжүүлэлт"-ОНӨААТҮГ-тай байгуулан гүйцэтгүүлэн санхүүжилтийг олгосон.	7

Зарсан

2	5	"Аймгийн төвийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажил"-ыг 300.0 сая төгрөгөөр гэрээгээр гүйцэтгэсэн Зуунмод цэцэрлэгжүүлэлт-ОНӨААТҮГ-т 1.3 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон. Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3.2.5-д "барилга байгууламжийн зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт бичиг, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.	1,278.9 төлбөрийн акт	Хүлээн зөвшөөрч байна.	Акт
3	3	90.0 сая төгрөгийн санхүүжилттэй Зуунмод сумын дотор замын их засварт 2.9 сая төгрөг, нийт 5.7 сая төгрөгийг гүйцэтгэгч Төв АЗЗА ТӨХК-д илүү шилжүүлсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3.2.5-д "барилга байгууламжийн зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт бичиг, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.	2.9 төлбөрийн акт	Хүлээн зөвшөөрч байна.	Акт
		301,278.9			
		Нийт дүн			

Бэлтгэсэн:

Аудитор

Ч.Загдсүрэн

ЗДТГ-ын дарга

Г.Батжаргал

С.Мөнх-Амгалан

Аудитын менежер

Анхан шатанд янасан:

О.Амаржаргал

Танилцаж зөвшөөрсөн:



МХАА.0031.0158423

Хоёр дахь шатанд хийсэн: Ц.Хишигжаргал

Тэргүүлэх аудитор





ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 142-А/1970402-ТӨАГ-2024/18-18-ШТА-ГА

Зуунмод сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Аймгийн төвийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажил"-ыг гүйцэтгэсэн Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-тай нийт 299,965,306.0 төгрөгийн 16 гэрээ байгуулж, санхүүжүүлэхдээ 151,058,024.0 төгрөгийн 8 ажилд 1,278,896.0 төгрөгийн захиалагчийн зардлыг илүү олгосон.

Энэ нь "Төсвийн тухай хууль"-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3.2.5-д "барилга байгууламжийн зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт бичиг, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 1,278,896.0 (Нэг сая хоёр зуун далан найман мянга найман зуун ерэн зургаа) төгрөгийг Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-аар төлүүлэн Төв аймгийн Төрийн сан банк дахь Тө.Хүү, торгуулийн орлогын 100140000988 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Зуунмод сумын ЗДТГ-ын дарга Г.Батжаргал, ахлах мэргэжилтэн С.Мөнх-Амгалан нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

Ч.ЗАГДСҮРЭН

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

010950603



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 143-А1970402-ТӨАГ-2024/18-18-ШТА-ГА

Зуунмод сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн замын сангаас Зуунмод суманд эрх шилжиж хэрэгжсэн 89,990,156.0 төгрөгийн гэрээтэй Зуунмод сумын дотор замын их засварын ажлын захиалагчийн зардал 2,944,597.0 төгрөгийг гүйцэтгэгч Төв АЗЗА ТӨХК-д илүү шилжүүлсэн байна.

Энэ нь “Төсвийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3.2.5-д “барилга байгууламжийн зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт бичиг, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Илүү олгосон 2,944,597.0 (Хоёр сая есөн зуун дөчин дөрвөн мянга таван зуун ерэн долоо) төгрөгийг Төв АЗЗА ТӨХК-аар төлүүлэн Төв аймгийн Төрийн сан банк дахь Тө.Хүү, торгуулийн орлогын 100140000988 тоот дансанд төвлөрүүлэх,
- Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Зуунмод сумын ЗДТГ-ын дарга Г.Батжаргал, ахлах мэргэжилтэн С.Мөнх-Амгалан нарт хариуцуулав.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

Ц.ХИШИГЖАРГАЛ

Ч.ЗАГДСҮРЭН

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019050607

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн
Аудитын код: ТӨАГ-2024/18-18-ШТА-ГА

Байгууллагын нэр: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

№	Аудитын чиглэл/асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (Мянган төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
A	1	3	4	5	6	7
1		Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн 793,464,504.0 төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын ажлын зохиогчийн хяналтыг 6,758,678.0 төгрөгөөр санхүүжүүлэхээс 9,438,799.0 төгрөгөөр санхүүжүүлж 2,680,121.0 төгрөгийг аймгийн хөрөнгө оруулалтын зардлаас давхардуулан илүү олгосон.	2,680.1	Төлбөрийг барагдуулах төлбөрийн акт	Хүлээн зөвшөөрсөн	Төлбөрийн акт
2	Б.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон уу?	Төв АЗЗА компанийн гүйцэтгэсэн 199,990,606.0 төгрөгийн гэрээтэй Зуунмод сумын авто замын өвөл, зуны арчлалтын магадлалгүй ажлын зардал 2,816,756.0 төгрөгийг давхардуулж олгосон.	2,816.8	Төлбөрийг барагдуулах төлбөрийн акт	Хүлээн зөвшөөрсөн	Төлбөрийн акт
3		Эрдэнэсант сумын соёлын төвийн их засварын ажлын 466.3 сая төгрөгийн гэрээг 2023 оны 06 дугаар сарын 26-нд Юу зэт эрдэнэ ХХК-тай байгуулж, 6 дугаар сарын 30-нд 301.8 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг олгожээ. Тендерийн бичиг баримтад урьдчилгаа санхүүжилт олгохгүй гэж заасан боловч урьдчилгаа санхүүжилтэд нийт санхүүжилтийн 65 хувийг олгосон.	301,788.4	зөрчлийг давтан албан шаардлага	Хүлээн зөвшөөрсөн	Албан шаардлага
		Нийт дүн	307,285.3			

Бэлтгэсэн:

Аудитор Ахлах аудитор Ч.Загдсүрэн

Л.Жаргалсайхан

Хэлтсийн дарга

Мэргэжилтэн

Аудитын менежер

Анхан шатанг хянасан:

О.Амаржаргал

Хоёр дахь шатанд хянасан:

Тэргүүлэх аудитор

Ц.Хишигжаргал

Танилцаж зөвшөөрсөн:

Д.Саран-Эрдэнэ

Ц.Баярмагнай



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 6 сарын 10 өдөр

Дугаар 140-A1970402-ТӨАГ-2024/18-18-ШТА-ГА

Зуунмод сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн 793,464,504.0 төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын ажлын зохиогчийн хяналтыг 6,758,678.0 төгрөгөөр санхүүжүүлэхээс 9,438,799.0 төгрөгөөр санхүүжүүлж 2,680,121.0 төгрөгийг аймгийн хөрөнгө оруулалтын зардлаас Досей ХХК-д илүү олгосон байна.

Энэ нь "Төсвийн тухай хууль"-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3.2.5-д "барилга байгууламжийн зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт бичиг, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 2,680,121.0 (Хоёр сая зургаан зуун наян мянга нэг зуун хорин нэг) төгрөгийг Досей ХХК-аар төлүүлэн Төв аймгийн Төрийн сан банк дахь Тө.Хүү, торгуулийн орлогын 100140000988 тоот дансанд төвлөрүүлэх;

610050808

2. Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг ХБТХОХ-ийн дарга Д.Саран-Эрдэнэ, мэргэжилтэн Я.Пагмаажав нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

Ч.ЗАГДСҮРЭН

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 141-А1970402-ТӨАГ-2024/18-18-ШТА-ГА

Зуунмод сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв АЗЗА ТӨХК-ийн гүйцэтгэсэн 199,990,606.0 төгрөгийн гэрээтэй Зуунмод сумын авто замын өвөл, зуны арчлалтын магадалшгүй ажлын зардал 2,816,756.0 төгрөгийг аймгийн замын сангаас давхардуулж илүү олгосон байна.

Энэ нь “Төсвийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3.2.5-д “барилга байгууламжийн зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт бичиг, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Илүү олгосон 2,816,756.0 (Хоёр сая найман зуун арван зургаан мянга долоон зуун тавин зургаа) төгрөгийг Төв АЗЗА ТӨХК-аар төлүүлэн Төв аймгийн Төрийн сан банк дахь Тө.Хүү, торгуулийн орлогын 100140000988 тоот дансанд төвлөрүүлэх;
- Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг ХБТХОХ-ийн дарга Д.Саран-Эрдэнэ, мэргэжилтэн Я.Пагмаажав нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

Ч.ЗАГДСҮРЭН

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

610050602



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар _____

193-A1970402-ТӨАГ-2024/18-18-ШТА-ГА

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэсант сумын соёлын төвийн их засварын ажлын 466,321,896.0 төгрөгийн гэрээг 2023 оны 06 дугаар сарын 26-нд Юу зэт эрдэнэ ХХК-тай байгуулж, 6 дугаар сарын 30-нд 301,788,403.0 төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг олгожээ. Тендерийн бичиг баримтад урьдчилгаа санхүүжилт олгохгүй гэж заасан боловч урьдчилгаа санхүүжилтэд нийт санхүүжилтийн 65 хувийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.12-т “Төслийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно: 4.1.12.1.тухайн төсөлд урьдчилгаа олгох талаар худалдан авах ажиллагааны баримт бичиг болон гэрээнд тусгасан байх; 4.1.12.2.урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулсан байх (Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Урьдчилгаа төлбөрийн баталгааны маяг”-ын дагуу гаргана); 4.1.12.3.банкны урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн санхүүжилтийг олгоход урьдчилгаа төлбөрийн банкны баталгааг банканд байршуулсан эсэх баримтыг санхүүжилт хүсэх баримтад хавсаргасан байх; 4.1.12.4.төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын улсын төсвийн санхүүжилтээр санхүүжих төслийн урьдчилгаа төлбөрийн хэмжээ нь тухайн онд батлагдсан нийт санхүүжилтийн 30 хувиас ихгүй байна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Тухайн төсөлд урьдчилгаа олгох талаар худалдан авах ажиллагааны баримт бичигт тусгаагүй, урьдчилгаа төлбөрийн баталгаагүй олгосон 301,788,403.0 (Гурван зуун нэг сая долоон зуун наян найман мянга дөрвөн зуун гурван) төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

019050801

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ХБТХОХ-ийн дарга Д.Саран-Эрдэнэ, мэргэжилтэн Я.Пагмаажав нарт даалгав.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.ХИШИГЖАРГАЛ
Ч.ЗАГДСҮРЭН

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн

Аудитын код: ТӨАГ-2024/18-18-ШТА-ГА

Байгууллагын нэр: Орон нутгийн өмчийн газар

№	Аудитын чиглэл/асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (Мянган төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
A	1	3	4	5	6	7
1	В.2. Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан уу?	Барилга, байгууламж ашиглалтад хүлээн авах комиссын актаар хүлээн авсан Эрдэнэсант сумын соёлын төвийн 466.3 сая төгрөгийн их засвар,Баянхошуу баг чиглэлийн 490.0 сая төгрөгийн авто зам /Зуунмод/-ыг данс бүртгэлд тусгаагүй байна.	956,300.9	Хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, зөрчлийг арилгах албан шаардлага	хүлээн зөвшөөрсөн	Албан шаардлага өгөх
		Нийт дүн	956,300.9			

Бэлтгэсэн:

Ахлах аудитор

Аудитор

Л.Жаргалсайхан

Ч.Загдсүрэн

Орон нутгийн өмчийн газрын дарга
Өмчийн бүртгэл, ашиглалт, зохицуулалт хариуцсан
ахлах мэргэжилтэн

Д.Батжаргал
Г.Уранцэцэг

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер

Хоёр дахь шатанд хянасан:

Тэргүүлэх аудитор

Ц.Хиширжаргал





ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар _____

192-A1970402-ТӨАГ-2024/18-18-ШТА-ГА

Зуунмод

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Барилга, байгууламж ашиглалтад хүлээн авах комиссын актаар хүлээн авсан Эрдэнэсант сумын соёлын төвийн 466,321,896.0 төгрөгийн их засвар, Баянхошуу баг чиглэлийн 489,979,024.0 төгрөгийн авто зам /Зуунмод/, бүгд 956,300,920.0 төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-т “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.5.1-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Данс бүртгэлд тусгаагүй 956,300,920.0 (Есөн зуун тавин зургаан сая гурван зуун мянга есөн зуун хорь) төгрөгийн 2 хөрөнгийг бүртгэн, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

019050793

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Батжаргал, ахлах мэргэжилтэн Г.Уранцэцэг нарт даалгав.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.ХИШИГЖАРГАЛ

Ч.ЗАГДСҮРЭН

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн
Аудитын код: ТӨАГ-2024/18-18-ШТА-ГА
Байгууллагын нэр: Зуунмод цэцэрлэгжүүлэлт-ОНӨААТҮГ

№	Аудитын чиглэл/асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (Мянган төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
A	1	3	4	5	6	7
1	Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл үндэслэн санхүүжилтийг олгосон уу?	"Аймгийн төвийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажил"-ыг гүйцэтгэсэн Зуунмод цэцэрлэгжүүлэлт-ОНӨААТҮГ-ын 300.0 сая төгрөгийн гэрээт ажлын төсөв болон гүйцэтгэлийн баримтад материалын зардалд хар шороог 3 янзын үнээр тооцож санхүүжээний үнийн зөрүү 0.6 сая төгрөг, мөн Одонт хөтлөөс хаан банк хүртэл нийт 48 ширхэг цэцгийн сав хийж, цэцэг тарих ажлын төсөвт цэцгийн савыг цутгаж хийхээр байсныг өөрчилж хийхдээ хуучин төсвөөр гүйцэтгэлийг гаргаж санхүүжсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.12.Төслийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох, 4.1.33.Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно" гэсэн заалтууд зөрчилдсөн байна. /Тооцооллыг хавсралтаар/	10,334.0	10,334.0 төлбөрийн акт	Одонт хөтлөөс ХААН банкны уулзаар 48 ширхэг цэцгийн савыг хийхдээ төсөвт материалууд нь дутуу тусгагдсан байна. Үүнд: 1. Шрупп 100ш хайрцаг х 5000 төг=500 000 төг 2. Лаз 18л х 7 х 90000төг = 630 000 төг 3. Замаск 3 ш х 350000төг=105 000 төг 4. Зүлгүүр 100ш х 500төг = 50 000 төг 5. Хөрөө рамны ир 3ш х40000= 120 000 төг Нийт -1 405 000 төгрөг Мөн 1 цэцгийн сав хийхэд зарцуулдаг банз, дүнзэнцэр гэсэн модон материалыг төсөвт 1 цэцгийн савныхаар тооцсон байх тул 48 аар тооцож, зардлаас хасаж өгнө үү.	Төсөвт дутуу тооцсон материалын зардлыг хасч 2,286,190 төгрөгөнд төлбөрийн акт бичих
3			10,334.0			
	Нийт дүн					

Бэлтгэсэн:

Аудитор Ч.Зандорж

Танилцаж зөвшөөрсөн:


Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын захирал

Анхан шатанд хамтсан: О.Амаржаргал

Аудитын менежер

Хоёр дахь шатанд хянагч: Ц.Хишигжаргал

Тэргүүлэх аудитор





ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 144-А/1970402-ТӨАГ-2024/18-18-ШТА-ГА

Зуунмод сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Аймгийн төвийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажил"-ыг гүйцэтгэсэн Зуунмод цэцэрлэгжүүлэлт-ОНӨААТҮГ-ын 299,965,306.0 төгрөгийн гэрээт ажлын төсөв болон гүйцэтгэлийн баримтад материалын зардалд хар шороог 3 янзын үнээр тооцож санхүүжсэний үнийн зөрүү 598,200.0 төгрөг, мөн Одонт хөтлөөс хаан банк хүртэл нийт 48 ширхэг цэцгийн сав хийж, цэцэг тарих ажлын төсөвт цэцгийн савыг цутгаж хийхээр байсныг өөрчилж хийхдээ хуучин төсвөөр гүйцэтгэлийг гаргаж санхүүжсэнээс 2,286,190.0 төгрөг, нийт 2,884,394.0 төгрөгийн санхүүжилт илүү олгосон байна.

Энэ нь "Төсвийн тухай хууль"-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.12-т "Төслийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох", 4.1.33-т "Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 2,884,394.0 (Хоёр сая найман зуун наян дөрвөн мянга гурван зуун ерэн дөрөв) төгрөгийг Зуунмод цэцэрлэгжүүлэлт-ОНӨААТҮГ-аар

• 019050611

төлүүлэн Төв аймгийн Төрийн сан банк дахь Тө.Хүү, торгуулийн орлогын 100140000988 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Зуунмод цэцэрлэгжүүлэлт-ОНӨААТҮГ-ын захирал Г.Жаргалцэцэг, нягтлан бодогч Д.Мягмарсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Ч.ЗАГДСҮРЭН

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

Шалгадагч байгууллагаас ирүүлсэн тайлбарын дагуу
"Модон цэцгийн савны материалын зардал"-ын дахин хийсэн

№	Материалын нэр	хэмжих нэгж	төсөвт тооцсон			нийт зардал
			нэгж үнэ	орц	нийт үнэ	
1	ус	м3	1,000.0	13.3794	13,379.4	6,689.7
2	хар шороо	м3	30,000.0	6.16	184,800.0	92,400.0
3	хадаас	кг	6,500.0	8.33	54,142.4	27,071.2
4	хөвөө мод	м	7,500.0	52.90	396,720.0	396,720.0
5	цэцэг	кг	13,000.0	125.80	1,635,400.0	817,700.0
6	цаасан зүлгүүр	м2	6,000.0	1.62	9,703.8	9,703.8
7	бууц	м3	3,000.0	0.34	1,020.0	510.0
8	гялгар уут	кг	12,000.0	0.30	3,648.0	3,648.0
9	дүнзэнцэр	м3	220,000.0	11.67	2,568,192.0	2,568,192.0
10	банз	м3	220,000.0	4.08	897,600.0	897,600.0
11	үжил эсэргүүцэгч	кг	3,200.0	4.30	13,755.5	13,755.5
	Бүгд					4,833,990.22
	Нэг цэцгийн саванд ноогдох зардал					201,416.26
	24 ш-ийн дүн					4,833,990.22
	төсөвт тусгасан материалын зардал					6,679,585.00
	төсөвт тусгасан материалын зардлын зөрүү					1,845,594.78
	48 ш цэцгийн савны материалын зардлын зөрүү					3,691,189.56
	Дутуу тооцсон материалын үнийн дүн					1,405,000.00
						2,286,189.56

Тооцоог хийсэн: Аудитор

Тооцоотой танилцсан: Зуунмод цэцэрлэгжүүлэлт
ОНӨААТҮГ-ын захирал:

Г.Жаргалцэцэг

Материалын үнийн зөрүү

№	Ажлын нэр	зөрчлийн утга	Төсөвт тусгасан нэр	Х/нэгж	нийт	цалин/ орц	төсөвт/ үнэ	хувь	нийт цалинд ноогдох
1	1000 айлаас эмнэлэг хүртэлх модны хөрс сольж зүлэг цэцэг	материалын зардал үнийн зөрүү	хар шороо	м3	508,400.00	25.42	20,000.00		152,520.00
2	Цэнгэлдэх хүрээлэнд 40 ширхэг цэцгийн сав хийж тарих ажлын урьдчилгаа санхүүжилт	материалын зардал үнийн зөрүү	хар шороо	м3	184,800.00	6.16	30,000.00		98,560.00
3	Эмнэлгээс дивиз хүртэлх модны хөрсийг сольж зүлэг тарих	материалын зардал үнийн зөрүү	хар шороо	м3	500,000.00	25.00	20,000.00		150,000.00
4	Цагаан хаалганаас хаан банк хүртэл 24 ш цэцгийн сав хийж, цэцэг тарих	материалын зардал үнийн зөрүү	хар шороо	м3	184,800.00	6.16	30,000.00		98,560.00
5	Одонт хөтлөөс цагаан хаалганаас хаан банк хүртэл 24цэцэг тарих	материалын зардал үнийн зөрүү	хар шороо	м3	184,800.00	6.16	30,000.00		98,560.00
	БҮГД								598,200.00

Тооцоог хийсэн: Аудитор

Тооцоотой танилцсан: Зуунмод цэцэрлэгжүүлэлт

ОНӨААТҮГ-ын захирал.

Ч.Зардсүрэн



Г.Жаргалцэцэг

АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

Аудитын нэр: Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн
Аудитын код: ТӨАГ-2024/18-18-ШТА-ГА
Байгууллагын нэр: Аймгийн БЗОСК ОНӨААТҮГ

№	Аудитын чиглэл/асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (сая төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
A	1	2	3	4	5	6
1	A.3 Худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, зохион байгуулж, шаардлага хангасан гүйцэтгэгч шалгаруулсан уу?	Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд 2022 онд 800.0 сая төгрөг, 2023 онд 800.0 сая төгрөг батлагдсан, тендер шалгаруулалт 2022 онд явагдаж Төв цогт өлзийт ХХК шалгарсан. Захиалагчаар БЗОСК ОНӨААТҮГ томилогдож худалдан авах ажиллагааны захиалга /түрээсийн орон сууц хэрэгжүүлэх ажлын сонгон шалгаруулалтын урилга 2022.04.11/ өгөхдөө 40 айлын орон сууцны барилга болгон өөрчилж, төсөвт өртгийг 3,000.0 сая болгон өөрчилсөн байна. Аймгийн ИТХ-аар баталсан төсөвт өртгийг өөрчилсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 ¹ болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 ² заасныг, орон сууцны барилга болгон өөрчилсөн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29 ¹ .2.2 ³ болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-д заасныг тус тус зөрчсөн байна.	3000.0	Албан шаардлага	2022 онд аймгийн төвд орон сууцны барилга угсралтын ажил эхэлсэн болон дууссан барилга байгаагүй тул төсвийг үр өгөөжтэй байлгах үүднээс 40 айлын орон сууц барихаар тендер зарласан. 40 айлын орон сууцны өмнөх оны жишиг үнэ 3 тэрбум хавьцаа байсан тул 3 тэрбумаар тендер зарласан. Төв өргөө ХХК-ын 40 айлын орон сууцны нэг маягийн зургаар холболт хийх нөхцөлөөр зарлаж, тус зурагт төсөв хийхэд 3.8 тэрбум болж өссөн.	

¹ 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

² 46.1.4.худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах;


³ 29¹.2.2.барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

2	Б.1. Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь, холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлсэн үү?	Мөн Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор багтагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.Төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага: 3.2.2.2.барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх гэснийг хангаагүй байна. Тендерийн баримт бичигт төсөвт өртгийг 3,000.0 сая төгрөг гэсэн байхад тус компани 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 01/29 тоот албан бичгээр 3,867.7 сая төгрөгийн үнийг санал, 01/30 тоот албан бичгээр 1 мкв-ын үнийн санал НӨАТ орсон 1.9 сая төгрөг /нийт 1952.2 мкв 1.9 сая төгрөгөөр тооцоход 3,709.2 сая төгрөг/ гэж өгчээ. Тендерийн баримт бичигт тусгагдсан төсөвт өртгөөс хэтэрсэн, ирүүлсэн 2 үнийн санал нь зөрүүтэй байхад үнэлгээний хороо шалгаруулсан байна. Төв цогт өлзийт ХХК-тай 2022 оны 6 дугаар сарын 30-нд 40 айлын орон сууц 3,867.7 сая төгрөгөөр барих гэрээ байгуулсан /гэрээний дуусах хугацаа 2023 оны 9 дүгээр сарын 30/, 2023 оны 12 дугаар сарын 22-нд нэмэлт гэрээ болгон өөрчлөлт оруулсан. Гэрээний үлдэгдэл санхүүжилтийг аймгийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх боломжгүй болсон тул 1 мкв-г 2.0 сая төгрөгөөр тооцон нийт 800 мкв талбайд ноогдох 18 ширхэг орон сууц авахаар болгож нэмэлт гэрээ байгуулжээ. Аймгийн Засаг даргын орлогч, ХБТХО-ын хэлтсийн дарга, ОНӨГ-ын дарга, БЗОСК ОНӨААТҮГ-ын захирал, хяналтын инженер, Төв цогт өлзийт ХХК-ын захирал гэсэн бүрэлдэхүүн 2023 оны 11 дүгээр сарын 31-ны өдөр хуралдаж, 1,600.0 сая төгрөгт 1 мкв-г 2.0 сая төгрөгөөр тооцон нийт 800 мкв орон сууц авахаар шийдвэрлэсэн байна.	80.0	Албан шаардлага	Тендер зарлахад гадна шугам сүлжээний ажил ажлын тоо хэмжээнд ороогүй тул барилга угсралтын ажлын явцад гадна дулаан, цэвэр бохир ус, гадна цахилгаан, гадна холбоо зэргийн ажил хийх зайлшгүй шаардлагатай гарсан. Гүйцэтгэгч Төвцогт өлзийт ХХК нь өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн. Үнээс үүдэж Төв аймгийн орон сууцны зөвлөл хуралдаж 1м2-ийн үнийг 2 сая төгрөгөөр тооцон авахаар тогтсон.	
---	--	---	------	-----------------	--	--

				Төв цогт өлзийт ХХК-аас 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр захиалагч байгууллагад хүсэлт гаргаж, улмаар аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн а/818 тоот захирамж гарч, гэрээнд өөрчлөлт оруулжээ. Дээрх хурлын тэмдэглэлд гүйцэтгэгч компанийн тендерт санал болгосон үнэ 1 мкв нь 2.0 сая төгрөг гэж танилцуулагдаж дээрх шийдвэрүүд гарсан байна. Гэтэл Төв цогт өлзийт ХХК нь тендерт оролцохдоо буюу 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 01/30 албан бичгээр 1 мкв-ын үнэ 1.9 сая төгрөг, НӨАТ-ын 10 хувь батсан үнэ гэж үнийн санал хүргүүлж улмаар тендерт шалгарсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-д “Шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь тендерийн үнэ байна” гэж заасан байтал тендерт санал болгоогүй үнээр тооцож 1 мкв-ын үнийн зөрүүгээс орон нутгийн төсөвт 80.0 сая төгрөгийн хохирол учирсан байна.	
--	--	--	--	--	--

Бэлтгэсэн:

Ахлах аудитор



Л.Жаргалсайхан Огноо: 2024.05.27

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер О.Амаржаргал Огноо:2024.05.27



Хоёр дахь шатанд хянасан:

Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал Огноо:2024.05.27



Танилцаж зөвшөөрсөн:

Захирал



Ж.Баттөгс

Хяналтын инженер



Г.Хишигдорж





ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар _____

201-А1960398-ТӨА-2024/18-18-ШТА-ГА

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх Төв цогт өлзийт ХХК-тай байгуулсан гэрээнд өөрчлөлт оруулахдаа тендерт санал болгосон 1 мкв нь 1.9 сая төгрөгийг материалын үнийн зөрүү гэж 2.0 сая төгрөг болгон өөрчилж, 80.0 сая төгрөгийн зөрүүг гүйцэтгэгчид олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4-д “Худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах, Улсын Их Хурлын 2022 оны 72 дугаар тогтоолын 1.1-д “УИХ-ын 2021 оны 88 дугаар тогтоолд үндэслэн Барилга, хот байгуулалтын яамнаас баталгаажуулсан барилгын материалын үнийн өсөлтөөс үүдсэн төсөвт өртгийн нэмэгдлээс бусад улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдлийг Төрийн аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн шаардлагатай бол төсвийн хуульд тусган шийдвэрлүүлэх”, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл эрх хүлээн авсан этгээд нь төслийг батлагдсан төсөвт өртөгт багтаан худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах үүрэгтэй”, 4.1.32-т “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй хөрөнгө оруулалтын төслийг төсвөөс санхүүжүүлэхийг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.-т

019050832

“Аудитын баг аудитын алдаа, зөрчлийг үнэлж, албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох шийдэл гаргахдаа дараах нөхцөлийг харгалзана...”, 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй ажиллах,
2. Албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг аймгийн БЗОСК ОНӨААТҮГ-ын захирал Ж.Баттөгс, хяналтын инженер Г.Хишигдорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

Л.ЖАРГАЛСАЙХАН



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 202-А1960398-ТӨА-2024/18-18-ШТА-ГА

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд 2022, 2023 онуудад тус бүр 800.0 сая төгрөг батлагдсан байхад Захиалагч БЗОСК ОНӨААТҮГ 2022 онд 40 айлын орон сууцны барилга болгон, төсөвт өртгийг 3,000.0 сая болгон өөрчилсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 29 дүгээр зүйлийн 29.4-д "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана", 29¹.2.2-д "барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4-д "Худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-д "техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ", Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.2-т "Төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага", 3.2.2.2-т "барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.-т "Аудитын баг аудитын алдаа, зөрчлийг үнэлж, албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох шийдэл гаргахдаа дараах нөхцөлийг харгалзана...", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй ажиллах,
2. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ИТХ-р батлагдсан төсөвт өртөг, зориулалтыг өөрчлөхгүй байж албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг аймгийн БЗОСК ОНӨААТҮГ-ын захирал Ж.Баттөгс, хяналтын инженер Г.Хишигдорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

Л.ЖАРГАЛСАЙХАН

019050926